



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



ЭКСПОРТЫН БАРИМЖААТАЙ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ЭКСПОРТОД ГАРГАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

ТАЙЛАН

Гэрээний дугаар: CS-2-20/21

Гэрээт ажлын нэр: Экспортын баримжаатай хүнсний бүтээгдэхүүнийг экспортод гаргах шаардлагууд болон зах зээлийн судалгааг гаргах

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН: ТӨСЛИЙН БАГИЙН ГИШҮҮД

ХЯНАСАН: Л.ТУНГАЛАГ, ТӨСЛИЙН БАГИЙН АХЛАГЧ

УЛААНБААТАР ХОТ

2022

Гарчиг

1. Ерөнхий зүйл	3
2. Төслийн хамрах хүрээ	4
2.1 Судалгаанд хамруулах улс орнууд	4
2.2 Судалгаанд хамруулах хүнсний бүтээгдэхүүн	5
3. Экспортын баримжаатай хүнсний бүтээгдэхүүний талаарх судалгааны үр дүнд үндэслэн гаргаж байгаа дүгнэлт, бодлогын зөвлөмж	7
VI Мэдээллийн менежментийн талаар	22
VII. Импортлогч орнуудын шаардлага	23
Тарифын зохицуулалт	23
Тарифын бус зохицуулалт	25
5.2 Монгол Улстай ижил төстэй ХАА-н үйлдвэрлэл бүхий улс орны судалгаа	Error!
Bookmark not defined.	
Хавсралт 1. Экспортын баримжаатай хүнсний бүтээгдэхүүнийг тодорхойлох аргачлал	31
Хавсралт 2. Монгол Улсаас экспортолсон хүнсний бүтээгдэхүүний судалгаа	34
Хавсралт 3. Монгол улсаас 2012-2021 онд экспортолсон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт	52
Хавсралт 4. Монгол улсаас 2012-2021 онд экспортолсон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт	54
Хавсралт 5. Экспортлох боломжтой бүтээгдэхүүний жагсаалт	62
Хавсралт 6. Экспортлох боломжтой хүнсний бүтээгдэхүүн	64
Хавсралт 7. Өрсөлдөх чадвар	66
Хавсралт 8. Хүнсний бүтээгдэхүүний экспортын багтаамжийн тухай	83
Хавсралт 11. ДХБ-ын хэлэлцээрүүд болон бусад хоёр ба олон талт худалдааны хэлэлцээрүүдэд Монгол Улс нэгдсэн байдал, түүний хэрэгжилт	Error! Bookmark not defined.
Хавсралт 12. Гадаад орны сайн туршлагаудаас	Error! Bookmark not defined.
Хавсралт 13. Чацаргана экспортлоход тулгарч буй хүндрэлүүд	Error! Bookmark not defined.
Хавсралт 15. Импортлогч орны Монголын хүнсний бүтээгдэхүүнд ноогдуулж байгаа Тарифын хэмжээ	Error! Bookmark not defined.
Хавсралт 16. Цаг үеийн байдлын тухай	Error! Bookmark not defined.
Хавсралт 17. Хүнсний Хяналтын Тогтолцоонд Дүн Шинжилгээ Хийсэн Тухай Танилцуулга	Error! Bookmark not defined.



1. Ерөнхий зүйл

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн “Алсын хараа 2050” бодлогын 3.3 дахь зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүнд заасан “...экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, экспортын зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх, бичил, жижиг, дунд бизнес олон улсад өрсөлдөх боломжийг бүрдүүлэх...”, 2.5, 8.3-т “...Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын менежмент, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэх, ...оюуны багтаамж өндөртэй, органик, Монгол брэндийн эко хүнс... экспортлох нөхцөлийг сайжруулах..., ...экспортын хэмжээг нэмэгдүүлэх” зорилт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.3, 3.4 дэх хэсэгт “Мал амьтан, ургамлын гаралтай органик хүнсийг баталгаажуулан, худалдааны түнш орнуудад хүлээн зөвшөөрүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд хүнсний бүтээгдэхүүний экспортын бодлогыг оновчлох зорилгоор дараах чиглэлээр судалгааг гүйцэтгэж байна:

1. Хүнсний экспортын чиглэлээр Монголд хуримтлагдсан туршлагыг судалж, эдийн засагт хувь нэмэр оруулахуйц бүтээгдэхүүний судалгааг гаргах;

2. Олон улсын худалдааны болон импортлогч орны (БНХАУ, ОХУ, БНСУ, Япон улс, Европын Холбооны улсууд, Арабын орнууд) тавьж байгаа шаардлагыг тодорхойлж, сонгогдсон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн экспортлох шат дараалласан мэдээллийг бэлтгэх;

3. Гадаад худалдааны зах зээлд өрсөлдөхөд тулгарч буй бэрхшээлийг бүтээгдэхүүн бүрээр тодорхойлох, шийдвэрлэх арга замыг оновчлох;

4. Хөгжлийн ижил нөхцөлд байгаа улс орны гадаад худалдааны сайн туршлагыг Монгол улсад нутагшуулах чиглэлээр санал боловсруулах;

5. Экспортын баримжаатай хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, олон улсад нэр хүнд бүхий Монгол Брэнд бий болгох талаар бодлого, стратегийн оновчтой шийдлийг боловсруулах.

Монгол Улсын экспортод чиглэсэн хүнсний нөөц, олон улсын зах зээлийн судалгааг хийж, экспорт-импортын хяналт, баталгаажуулалт, итгэмжлэлийн механизмыг тодорхойлж, дээрх шаардлагын дагуу уул уурхайн бус экспортыг дэмжих төрийн бодлогыг тодорхойлоход энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

2. Төслийн хамрах хүрээ

Төслийн даалгаварт БНХАУ, Япон, ОХУ, БНСУ, Европын холбоо, Арабын орнууд руу хүнсний бүтээгдэхүүний экспортлох боломжийг судлахаар тогтсон.

Хамрах хүрээг дараах хоёр чиглэлээр нарийвчлан тогтоож гаргав:

1. Судалгаанд хамруулсан улс орнууд;
2. Судалгаанд хамруулсан хүнсний бүтээгдэхүүн.

2.1 Судалгаанд хамруулах улс орнууд

Ажлын даалгаварын хүрээнд БНХАУ, Япон, ОХУ, БНСУ, Европын холбооны 15 улс, арабын 8 улс, нийт 27 улсыг доорх үндэслэлийг харгалзан хамруулав.

Европын холбооны тухайд 2022 оны байдлаар 27 улс багтаж байгаагаас Монгол Улсаас 2012-2021 онд хүнсний бүтээгдэхүүн импортлосон 15 улсыг энэхүү судалгааны хамрах хүрээнд багтааж, импортлосон үнийн дүнгээр эрэмбэлж жагсааж харуулав.

1. Итали улс
2. Нидерланд улс
3. Австри улс
4. Герман улс
5. Франц улс
6. Польш улс
7. Швед улс
8. Португал улс
9. Словак улс
10. Испани улс
11. Бельги улс
12. Чех улс
13. Дани улс
14. Унгар улс
15. Люксембург улс

Арабын орнуудын тухайд Арабын орнууд гэдэг ангилалд 22 улс багтаж байгаагаас 2012-2021 онд хүнсний бүтээгдэхүүн импортлосон 8 улсыг энэхүү судалгааны хамрах хүрээнд багтааж, импортлосон үнийн дүнгээр эрэмбэлж жагсааж харуулав.

1. Арабын Нэгдсэн Вант улс
2. Ливан
3. Египет
4. Саудын араб
5. Катар
6. Бахрейн
7. Кувейт
8. Арабын Бүгд Найрамдах Сири улс

2.2 Судалгаанд хамруулах хүнсний бүтээгдэхүүн

Судалгаанд хамруулах хүнсний бүтээгдэхүүнийг сонгоход дэлхийн худалдааны эргэлт дэх бараа бүтээгдэхүүний ангиллыг тогтооход ашигладаг Дэлхийн гаалийн байгууллагаас баталсан "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем" (БТКУС)-ийн кодыг ашигласан.

Судалгаанд БТКУС-ийн дараах хэсэг, бүлэгт хамаарах бүтээгдэхүүнийг хамруулав:

Хэсэг I- АМЬД МАЛ, АМЬТАД; МАЛ, АМЬТНЫ ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН

01- Амьд мал, амьтад.

02- Мах, дайвар мах.

03- Загас, хавч төрөлтөн, нялцгай биетэн болон усны сээр нуруугүй бусад амьтад.

04- Сүү, цагаан идээ; шувууны өндөг; зөгийн цэвэр бал; мал амьтны гаралтай, бусад газар заагдаагүй хүнсний бүтээгдэхүүн.

05- Мал амьтны гаралтай, бусад газар заагдаагүй бүтээгдэхүүн.

Хэсэг II- УРГАМЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН

06- Мод болон бусад ургамал; булцуу, үндэс ба эдгээртэй төстэй ургамлын бусад хэсэг; амьд цэцгийн баглаа болон чимэглэлийн ургамал.

07- Хүнсний ногоо болон зарим үндэс үрт ба булцуут үрт хүнсний ногоо.

08- Хүнсэнд хэрэглэдэг жимс болон самар; жүржийн төрлийн жимсний эсвэл гуаны хальс.

09- Кофе, цай, парагвай цай болон амтлагч

10- Үр тариа.

11- Гурилын үйлдвэрийн бүтээгдэхүүн; амуу соёолж; цардуул; инулин; буудайн цавуулаг.

12- Тослог үр, жимс; бусад үр, жимс; үйлдвэрлэлийн эсвэл эмнэлгийн зориулалттай ургамал; сүрэл болон тэжээл.

14- Сүлжих зорилгоор ашиглах ургамлын гаралтай материал; ургамлын гаралтай бусад газар заагдаагүй бүтээгдэхүүн.

Хэсэг III- МАЛ, АМЬТНЫ ЭСВЭЛ УРГАМЛЫН ГАРАЛТАЙ ТОС, ТЭДГЭЭРИЙГ ЗАДАЛЖ БОЛОВСРУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН; ИДЭШНИЙ ӨӨХ, ТОС; МАЛ, АМЬТНЫ ЭСВЭЛ УРГАМЛЫН ГАРАЛТАЙ ЛАВ

15- Мал, амьтны эсвэл ургамлын гаралтай тос, тэдгээрийг задалж боловсруулсан бүтээгдэхүүн; идэшний өөх, тос; мал, амьтны эсвэл ургамлын гаралтай лав.

Хэсэг IV- ХҮНСНИЙ БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮН; СОГТУУРУУЛАХ БОЛОН СОГТУУРУУЛАХ БУС УНДАА, ЦУУ; ТАМХИ БОЛОН ТАМХИ ОРЛУУЛАГЧ

16- Мах, загас, хавч төрөлтөн, нялцгай биетэн эсвэл усны сээр нуруугүй бусад амьтдаар хийсэн хүнсний бэлэн бүтээгдэхүүн.

17- Саахар, саахран бүтээгдэхүүн.

18- Какао болон какаоны бэлдмэл.

-
- 19-** Үр тариан, гурилан, цардуулан эсвэл сүүн бэлдмэл; гурилан бүтээгдэхүүн.
20- Хүнсний ногоо, жимс, самраар эсвэл ургамлын бусад эд хэсгээр хийсэн бэлдмэл.
21- Хүнсний төрөл бүрийн бэлдмэл.
22- Согтууруулах бус ундаа, цуу.
23- Хүнсний үйлдвэрээс гарсан үлдэгдэл болон хаягдал; мал, амьтны бэлдмэл тэжээл.

Хэсэг VI- ХИМИЙН БОЛОН ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

31- Бордоо

3. Экспортын баримжаатай хүнсний бүтээгдэхүүний талаарх судалгааны үр дүнд үндэслэн гаргаж байгаа дүгнэлт, бодлогын зөвлөмж


3.1 Судалгааны ажлын хураангуй

Аюулгүй, зохистой хүнсээр хэрэглэгчийг худалдааны шударга зарчим баримтлан хангахын тулд улс орны онцлогт тохирсон хүнсний хяналтын үндэсний тогтолцоо (ХХҮТ) чухал юм. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах нь засгийн газрын үндсэн үүргүүдийн нэг бөгөөд Тогтвортой хөгжлийн зорилт 2 болон 3-т хүрэхтэй нягт холбоотой. Үүний зэрэгцээ хүнсний худалдаа шударга байх, хүнсний сүлжээн дэх бүх оролцогч талуудын эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэхэд хүнсний хяналтын тогтолцоо чухал үүрэгтэй байна.

Тогтолцоо гэдэг нь харилцан уялдаа болон харилцан үйлчлэл бүхий багц үйл явц гэж олон улсын менежментийн тогтолцооны цагаан толгой гэж мэргэжилтнүүд авч үздэг ISO 9001:2015 стандартад тодорхойлсон байдаг.

Тэгвэл хүнсний хяналтын тогтолцоо гэдэг нь хүнсний хяналтын үндэсний тогтолцоог боловсруулах, хөгжүүлэх, ажиллуулах, үнэлэх, сайжруулахыг багтаасан CAC/GL 82-2013 стандартад тодорхойлсноор дараах багц үйл явцуудаас бүрддэг:

- Бодлого тодорхойлох,
- Тогтолцооны загварыг гаргах,
- Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, савлах, хадгалах, тээвэрлэх, тээвэрлэх, харьцах, борлуулах үйл явцууд,
- Мониторинг ба тогтолцоонд дүн шинжилгээ хийх үйл явцууд.



Хүнсний хууль эрх зүйн хороо (CAC)-ноос хүнсний хяналтын үндэсний тогтолцоог бий болгоход баримтлах зарчим, удирдамжийг дараах баримт бичигт тогтоож өгсөн байна.

- CAC/GL 82-2013 Хүнсний хяналтын үндэсний тогтолцооны зарчим, удирдамж;

-
- CAC/GL 20-1995 Хүнсний импорт, экспортын хяналт, баталгаажуулалтын зарчим;
 - CAC/GL 26-1997 Хүнсний импорт, экспортын хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, ажиллуулах, үнэлэх, итгэмжлэхэд зориулсан удирдамж;
 - CAC/GL 47-2003 Хүнсний импортын хяналтын тогтолцооны удирдамж;
 - CAC/GL 25-1997 Импортлохоос татгалзсан хүнсний бүтээгдэхүүний талаарх мэдээллийг улс хооронд солилцох тухай удирдамж.
 - MNS CAC GL 34:2007 Хүнсний импорт ба экспортын хяналт баталгаажуулалтын тогтолцооны тэнцүү байдлын гэрээ боловсруулах арга зүйн заавар

Хүнсний хяналтын үндэсний тогтолцооны зарчим, удирдамж CAC/GL 82-2013 стандартад “Хүнсний хяналтын үндэсний тогтолцооны зорилго нь хэрэглэгчийн эрүүл мэндийг хамгаалах, хүнсний худалдаанд шударга байдлыг хангахад оршино” гэж заасан байна.

Монгол Улсын Хүнсний тухай хуулийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь хүн амын хүнсний хэрэгцээг чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэж тогтоосон нь CAC/GL 82-2013 стандартад өгсөн хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой чиглэлд нийцэж байна.

ХХҮТ-ны үндсэн элементүүд, бүрэлдэхүүнүүдийг үндэсний нөхцөл байдалд тохируулан, Хүнсний хяналтын үндэсний тогтолцоонд зориулсан зарчим, удирдамж (CXG 82-2013) стандартад тайлбарласан. Энэ баримт бичигт Аюулгүй, зохистой хүнсээр хангах 12 зарчмыг, хяналтын төрөл бүрийн аргуудын хамт санал болгосон.

Монгол Улсын ХХҮТ-г авч үзвэл ХХҮТ-нд байвал зохих элементүүдийг бид хэрэглэж байна, харин тэдгээрийн уялдааг хүнсний аюулгүй байдлын бодлогыг хангах хэмжээнд хэрэглэж чадахгүй байна.

Тухайлбал, Хүнсний хяналтын тогтолцоонд техникийн хяналт болон баталгаажуулалтын тогтолцоо түлхүүр үүрэгтэй байдаг. Олон улсын стандартчиллын байгууллагаас үүнийг тохирлын үнэлгээ гэж нэрлэдэг юм.

Монгол Улсын Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4.1.6-д заасан ёсоор "тохирлын үнэлгээ" гэж бүтээгдэхүүн, ажилтны ур чадвар, менежментийн тогтолцоо нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг ойлгох ба үүнд сорилт, хяналт ба баталгаажуулалт хамаардаг.

CAC GL 20-1995 Хүнсний импорт, экспортын хяналт, баталгаажуулалтын зарчим стандартад

Баталгаажуулалтыг хүнс эсвэл хүнсний хяналтын тогтолцоо нь шаардлага хангаж байгаа баталгааг албан ёсны баталгаажуулалтын байгууллага болон албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаас бичгээр буюу түүнтэй адилтгах аргаар үнэлгээ өгөх үйл ажиллагаа гэж томъёолсон ба хүнсний баталгаажуулалт нь үйлдвэрлэлийн дамжлага дахь тасралтгүй хяналт, чанар үнэлгээний тогтолцооны хөндлөнгийн шалгалт, эцсийн бүтээгдэхүүнд хийх үзлэг, шалгалт зэргийг багтаасан хяналтын багц үйл ажиллагаанд үндэслэсэн байж болно гэж заажээ.

Харин **хяналтыг** үйлдвэрлэлийн явц болон бэлэн бүтээгдэхүүний сорилтыг хамруулан хүнс, эсвэл түүхий эд боловсруулалт, борлуулалт нь шаардлагад тохирч байгааг готлох хүнсний шалгалт гэж тодорхойлсон.

Хүнсний чанар, аюулгүй байдлыг нотолдог, дэлхийн дахинд хүлээн зөвшөөрөгдсөн хэрэгсэл бол тохирлын үнэлгээний үр дүн буюу хяналтын үр дүн эсвэл баталгаажуулалтын гэрчилгээ юм.

Гэхдээ тохирлын үнэлгээний үр дүнг ямар түвшинд хүлээн зөвшөөрөх вэ?

Манай хүнс экспортолдог аж ахуйн нэгжүүд “... монголын лабораторийн сорилтын үр дүн, тохирлын гэрчилгээг импортлогчид хүлээн зөвшөөрдөггүй” гэж гомдоллодог.

CAC GL 47-2003 Хүнсний импортын хяналтанд зориулсан удирдамж стандартад улс орнууд экспортлогч орны эрх бүхий байгууллагын хүнсний хяналтын тогтолцоог хүлээн зөвшөөрөх тухай заасан байна.

Хүнсийг импортлох нь өндөр хариуцлага тул импортлогч улсын эрх бүхий байгууллага нь тэр хариуцлагыг экспортлогч орны эрх бүхий байгууллагатай хуваалцах эрхтэй. Тиймээс, БНХАУ, ЕХ, Япон, БНСУ зэрэг улсууд аливаа хүнсийг импортлохоос өмнө экспортлогчийн хүнсний хяналтын тогтолцооны талаарх мэдээллийг цуглуулж, хэрэв өөрийн орны хүнсний хяналтын тогтолцоотой дүйцэж байвал тухайн хүнсний импортлох зөвшөөрлийг олгодог нийтлэг дүрэм үйлчилж байна.

Монгол Улсын баталгаажуулалтын байгууллагын үр дүнг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрдөг болгохын тулд манай улсын ХХҮТ наад зах нь Хүнсний хууль эрх зүйн хороо (CAC)-ны баримт бичигт нийцсэн байх шаардлагатай байна. Тиймээс НҮБ ХХААБ-аас гаргасан Хүнсний аюулгүй байдлын үнэлгээний хэрэгслийг ашиглан үнэлж, ХХҮТ-ны загварыг шинэчлэн гаргаж, бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхийг санал болгож байна.

[*Food control system assessment tool: Introduction and glossary*](#)

[*Food control system assessment tool: Dimension A – Inputs and resources*](#)

[*Food control system assessment tool: Dimension B – Control functions*](#)

[*Food control system assessment tool: Dimension C – Interaction with stakeholders*](#)

[*Food control system assessment tool: Dimension D – Science/knowledge base and continuous improvement*](#)

3.2 Судалгааны ажлын дүгнэлт

Монгол Улс БТКУС-ын 2 оронтой ангиллаар 24 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг, 68 улс руу сүүлийн 10 жилийн хугацаанд экспортолсон байна.

Хүнсний бүтээгдэхүүний экспортын талаар баримтлах төрийн бодлогыг оновчлох зорилготой судалгааны эхний үе шатанд 2012-2021 онд хүнсний экспортын чиглэлээр Монголд хуримтлагдсан туршлага дээр тулгуурлан төрөөс дэмжвэл зохих экспортын баримжаатай бүтээгдэхүүний нэр төрлийг тодорхойлж, санал болгов.

Судалгаанд ашигласан аргачлалыг [Хавсралт 1](#)-д таницуулав.

Монгол Улсаас экспортолсон хүнсний бүтээгдэхүүний судалгааг 2012-2021 оноор ажлын даалгаварт тогтоосон улсуудаар гаргасан. Монгол Улсаас экспортолсон хүнсний бүтээгдэхүүний судалгааг [Хавсралт 2](#)-т дэлгэрэнгүй оруулав.

Тайлангийн [Хавсралт 3](#) болон [Хавсралт 4](#)-т Монгол Улсаас экспортлох боломжтой гэж судалгааны багаас тодорхойлсон бүтээгдэхүүнийг БТКУС 2 болон 6 оронтой ангиллаар гаргаж, [Хавсралт 5](#)-д Экспортлох боломжтой бүтээгдэхүүнийг улс орнуудаар хуваарилсан байдлаар танилцуулсныг хүлээн авна уу.

Монгол Улсын сүүлийн 10 жилийн хугацаанд хийсэн хүнсний экспортын судалгаа, дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн зах зээлийн байдалд тулгуурлан НҮБ ХХААБ-ын баримталж байгаа бодлоготой уялдуулан ижил төстэй хөгжлийн баримжаатай улс орны туршлагад тулгуурлан дараах **Дүгнэлтийг Зөвлөмжийн** хамт гаргаж байна:

1. Экспортын баримжаатай бүтээгдэхүүний тухайд

1) Монгол Улсын 2021 оны бараа эргэлт 16 тэрбум ам.долларт хүрсэн нь 2020 оныхоос 25% өсөж, худалдааны тэнцэл 2.4 тэрбум долларын ашигтай гарав. Экспорт 9.3 тэрбум ам.долларт хүрч 22%, импорт 6.9 тэрбум доллар болж, 29% тус бүр өсжээ.

2) Экспортын барааны нийт дүнд

- эрдэс бүтээгдэхүүн 7.5 тэрбум доллар буюу 81.3%
- УРГАМЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН 89.3 САЯ АМ. ДОЛЛАР БУЮУ 1%
- сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс 1 тэрбум ам. доллар буюу 11.1%
- ХҮНСНИЙ БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮН 47.1 САЯ АМ.ДОЛЛАР БУЮУ 0.5%
- нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл 370.7 сая ам.доллар буюу 4%-ийг тус тус эзэлж эдгээр нь нийт экспортын дүнгийн 97.9 хувийг эзэлжээ.

3) Монгол Улс дэлхийн 64 оронд бараа, бүтээгдэхүүн экспортолсноос

- БНХАУ-д 82.6 хувь
- Швейцар-т 9.4 хувь
- Сингапурт 2.8 хувь
- БНСУ-д 2.4 хувь тус тус ногдож нийт экспортын 97.2 хувийг дээрх орнууд эзэлж байна.

4) Ковид 19 цар тахал нь үндэсний эдийн засагт үлэмж их хохирол учруулсан хэдий ч экспортын тухайд зарим эерэг нөлөө үзүүлсэн нэг жишээ бол хушны самрын экспорт юм. Монгол улсын хушны самар БНХАУ руу гардаг, тэндээс ЕХ руу экспортлогддог байсан бол “Ковидгүй улс болох тухай” БНХАУ-ын хатуу хөл хорионы дэглэмийн улмаас хушны самрын экспорт бусад бүтээгдэхүүний экспортын хамт зогсолтын байдалд орсон. ЕХ-ны импортлогчид энэ нөхцөлд байдалтай холбогдуулан монгол улсаас хушны самрыг шууд экспортлох арга замыг эрэлхийлж, холбогдох арга хэмжээг авсны үр дүнд хушны самар ЕХ руу Монголоос шууд экспортлох гарц нээгдсэн байна.

5) 2012-2021 оны хугацаанд хүнсний бүтээгдэхүүний экспорт үнийн дүнгийн хувьд 2.8-4.3 дээш дахин нэмэгдсэн байна.

6) Судалгаанд хамрагдсан улсуудын хүнсний экспорт, нийт хүнсний экспортын 88 орчим хувийг эзэлж байна. Судалгаанд хамрагдсан улсууд руу экспортолсон нийт бүтээгдэхүүнд хүнсний бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 2011 онд 0.95% байсан бол 2020 онд 2.2 % болж нэмэгдсэн байна.

7) 2012 онд БНХАУ-ын Монгол улсаас импортолсон хүнсний бүтээгдэхүүний хэмжээ нийт хүнсний экспортын 23% эзэлж байсан бол 2021 онд 89.7% болсон, Япон улсын хувьд 0.2%-оос 2.2% болж өссөн буюу үнийн дүнгээр авч үзвэл 30 дахин өссөн, ОХУ-ын хувьд 22% байсан бол 2021 онд 1% хүрэхгүй хэмжээнд хүрсэн буюу үнийн дүнгээр авч үзвэл 90 дахин буурсан; БНСУ-ын тухайд 1 орчим хувийг эзэлж байна, гэхдээ БНСУ руу экспортолсон хүнсний бүтээгдэхүүний хэмжээ 4-9 дахин нэмэгдсэн; ЕХ-ны тухайд 23,7% байсан бол 2021 онд 11,5% болж буурч, Арабын улсуудын хувьд 25% хүрч байсан бол 2021 онд 5.4% хүрч буурсан байна.

8) Монгол Улсаас БТКУС-ын 2 оронтой ангиллын 24 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг экспортолж байгаагаас БНХАУ руу 20, Япон руу 14, ОХУ руу 19, БНСУ руу 18, ЕХ-ны улсууд руу 16, Арабын улсууд руу 6 төрлийн бүтээгдэхүүнийг экспортолж байна.

Улс	Нийт хүнсний бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь		Экспортолж байгаа бүтээгдэхүүний төрөл
	2012 он	2021 он	
БНХАУ	23%	89.7%	20
Япон	0.2%	2.2%	14
ОХУ	22%	1%	19
БНСУ	1%	9%	18
ЕХ	23,7%	11,5%	16
Арабын улсууд	25%	5.4%	6

9) Монгол Улс уул уурхайн бус салбарт голчлон мал аж ахуйн бүтээгдэхүүнээр гадаад худалдаанд харьцангуй давуу талтай гэж эдийн засагчид үзэж байна. Экспортын баримжаатай хүнсний бүтээгдэхүүний талаарх мэрэгжлийн байгууллага болон экспортлогчдын саналыг судалгааны эхний шатанд хийсэн уулзалт, ярилцлагын үр дүн болон хүнсний бүтээгдэхүүний экспортын мэргэжилтэн, шинжээчдийн саналыг хураангуйлан [Хавсралт 6](#)-д танилцуулж байна.

10) Дэлхийн хүнсний бүтээгдэхүүний экспортын салбарт Монгол улсын зарим бүтээгдэхүүнүүд өрсөлдөх чадвартай байна. Тухайлбал, 2020 оны байдлаар Адууны махны

экспортоор Монгол улс дэлхийд 1-рт, Дулааны боловсруулалт хийсэн хонь, ямааны махны экспорт 8-рт, Рапс-16-рт, Гурвалжин будаа 23-т, Хушны самар 25-т тус тус эрэмбэлэгдэж байна.

Бүтээгдэхүүний нэр	Дэлхийд эрэмбэлэгдэж байгаа байдал
Адууны мах	1
Дулааны боловсруулалт хийсэн хонь, ямааны мах	8
Рапс	16
Гурвалжин будаа	23
Хушны самар	25

Экспортын хэмжээгээр дэлхийд эрэмбэлэгдсэн болон Монголоос импортлох боломжтой, эрэлт, хэрэгцээтэй дараах 13 нэр төрлийн бүтээгдэхүүний талаар олон улсын худалдааны төв (ИТС)-ийн <https://exportpotential.intracen.org> судалгааны үр дүнд дүнд үндэслэн гаргасныг Хавсралт 7-д танилцуулж байна.

1. Адууны мах (БТКУС)-0205
2. Боловсруулсан бог малын мах (БТКУС)-1602.9
3. Хушны самар (БТКУС)-0802
4. Рапс (БТКУС)-120590
5. Богийн өлөн гэдэс (БТКУС)- 050400
6. Боловсруулсан үхрийн мах (БТКУС)-160250
7. Хаягдал буудай (БТКУС)-230230
8. Эмийн ургамал (БТКУС)-1211
9. Гурвалжин будаа (БТКУС)- 100810
10. Аарц, Хуурай, шингэн, хөлдөөсөн, баяжуулсан, чацарганатай (БТКУС)- 040610
11. Хатуу/бусад бяслаг (БТКУС)- 040690
12. Ингэний хоормог, Шингэн, хатаасан (БТКУС)- 040390
13. Цөцгийн тос, 72-90% тослогтой; баяжуулсан (БТКУС)- 0405.10.00

11) Эдгээр бүтээгдэхүүний зах зээлийн судалгааны үр дүнд тус салбарт мэргэжлийн боловсон хүчний хомсдол, анхан шатны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн нь чанар, аюулгүй байдлын шаардлага хангахгүй байна, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн оновчтой логистикийн сүлжээ байхгүй зэргээс шалтгаалан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид бүрэн хүчин чадлаар ажиллаж чадахгүй, борлуулалтын орлого дорвитой нэмэгдэхгүй байна.

Тиймээс хүнсний бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулахын тулд

- (i) ХАА-н анхан шатны үйлдвэрлэлийн тогтолцоог сайжруулах,

-
- (ii) эцсийн болон завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, боловсруулах үйлдвэрүүдийн технологийг сайжруулах,
 - (iii) үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд таниулан сурталчлахад дэмжлэг үзүүлэх,
 - (iv) эдгээрт чиглэсэн тогтвортой санхүүжилтийн орчинг бий болгох шаардлагатай байна.

II Хүнс, хөдөө аж ахуйн зах зээл, гадаад худалдааны чиг хандлагын тухайд

12) Хөдөө аж ахуй бол дэлхийн эдийн засгийн чухал салбар юм. НҮБ ХААБ-ын 2021 жилийн статистик тоо баримтаас үзвэл 2000-2019 онд дэлхийн хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын үйлдвэрлэсэн нэмүү өртөг 73 хувиар өсч, 2019 онд 3.5 их наяд ам.долларт хүрчээ. Үүгээр ч зогсохгүй хөдөө аж ахуй 2020 онд 874 сая хүнийг ажлын байраар хангаж байгаа нь дэлхийн ажиллах хүчний 27 хувьтай тэнцэж байна.

Үйлдвэрлэлийн тухайд 2000-2019 оны хооронд газар тариалангийн үйлдвэрлэл 53 хувиар өсч, 2019 онд 9.4 тэрбум тонн болж, дээд амжилт тогтоосон байна. 2000-2018 оны хооронд махны үйлдвэрлэл хоёр дахин нэмэгдэж, 2000-2019 онд 44 хувиар өсөж, 337 сая тонд хүрчээ.

Үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэж байгаа хэдий ч, COVID-19 цар тахлын нөлөөн дор 2019-2020 оны хооронд хоол тэжээлийн дутагдлын тархалт дэлхийн түвшинд огцом өссөн байна. 2019 онд 8,4 хувьтай байсан бол 2020 онд дэлхийн хүн амын 10 орчим хувь нь өлсгөлөнгийн улмаас зовж шаналж байна.

Байгаль орчны тогтвортой байдлын талаас авч үзвэл ойн талбай багассан. Газар тариалангийн талбайн хүлэмжийн хийн ялгаруулалт 2000-2019 оны хооронд 2 хувиар буурсан ч хөдөө аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой хүлэмжийн хийн ялгарал 11 хувиар өссөн байна. Үүний 55 орчим хувь нь мал аж ахуйтай холбоотой байна.

Монгол улсын хүнсний бүтээгдэхүүний экспортод голлох байр суурь эзэлж байгаа мах, махан бүтээгдэхүүний хэрэгцээ дэлхийн хүн амын амьжиргааны түвшинд дээшилж байгаатай холбогдуулан нэмэгдсээр 2028 он гэхэд махны хэрэгцээ 40 сая тонн-д хүрэх тооцоо гарсан байна.

13) Хүнс, хөдөө аж ахуйн зах зээл, гадаад худалдааны чиг хандлагын талаар НҮБ-ын ХХААБ-аас хэвлэн гаргадаг Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн зах зээлийн байдал ¹(The State of Agricultural Commodity market-SOCO-2020) тайланд тусгажээ.

Дэлхийн хөдөө аж ахуйн зах зээл, гадаад худалдааны чиг хандлага Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахын тулд нэмүү өртгийн сүлжээ, жижиг фермер эрхлэгчид ба дижитал инновацийн асуудалд анхаарах шаардлагатай тухай дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

¹ 2020 Agricultural Markets And Sustainable Development: Global Value Chains, Smallholder Farmers And Digital Innovations

-
- Ядуурал, өлсгөлөнг арилгахгүйгээр тогтвортой ирээдүй гэж байхгүй. Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах нь хөдөө аж ахуйн үндсэн чиг үүрэг, тулгамдсан асуудал бөгөөд хүн амын тоо өсч, хотжилт нэмэгдэж, орлого өсөхийн хэрээр хөдөө аж ахуйн салбар аюулгүй, тэжээллэг хүнсний хэрэгцээг хангахад улам бүр чармайж ажиллах шаардлагатай;
 - Уур амьсгалын өөрчлөлт нь дэлхийн олон бүс нутагт улам бүр сөрөг нөлөө үзүүлж байгаа нь олон улсын худалдааны зах зээлийг тогтворжуулах, хүнсний хэрэгцээг илүүдэлтэй бүс нутгаас хомсдолтойд шилжүүлж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, хүнсний аюулгүй байдлыг хангахад хувь нэмрээ оруулах боломжтой.
 - Олон улсын худалдаа нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах хүчин чармайлтын гол төв болох боломжтой. Хэрэв нүүрсхүчлийн хийн ул мөр багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд анхаарах талаар тариаланчдад ойлгуулж чадвал дэлхий даяар хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах боломжтой.
 - Зах зээлийг илүү сайн ажиллуулахад тусалж, малчид, тариаланчдын дижитал технологийн хүртээмжийг сайжруулж чадна.

Мөн түүнчлэн, НҮБ-ын ХХААБ-аас хүнсний аюулгүй байдал, тогтвортой хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал, нянгийн тэсвэржил, шим тэжээл, амьтан, ургамлын эрүүл мэнд, загас агнуур, амьжиргаа зэрэг чиглэлээр ажиллаж буй "Нэг эрүүл мэнд"-ийг дэмждэг ба 2021 онд "Нэг эрүүл мэнд"-ийг хүн, амьтан, экосистемийн эрүүл мэндийг тогтвортой тэнцвэржүүлэх, оновчтой болгох зорилготой нэгдсэн, нэгдмэл арга гэж тодорхойлжээ.

НҮБ-ын ХХААБ нь НҮБ-ын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, холбогдох Тогтвортой хөгжлийн зорилтуудыг (ТХЗ) хэрэгжүүлэх нэн чухал аргуудын нэг бол Нэг эрүүл мэндийн арга болохыг танилцуулж, хэрэгжүүлэхийг уриалж байна.

Амьтнаас дамжсан вирусын улмаас үүссэн хүний эрүүл мэндийн хямрал болох COVID-19 цар тахлын дэлхийн хэмжээнд үзүүлж буй нөлөөлөл, хариу арга хэмжээ нь эрүүл мэндийг хамгаалах, хүнсний тогтолцоог тасалдуулахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр салбар хоорондын уялдаа холбоотой арга хэмжээ авах шаардлагатай байгааг харууллаа.

14) Хүнс, хөдөө аж ахуйн ирээдүй - 2050 он хүртэлх чиг баримжаа² баримт бичигт дэлхийн болон бүс нутгийн хүнс, хөдөө аж ахуйн тогтолцоог хөгжүүлэх нөлөөллийн хэтийн төлөвийг тодорхойлсон байна. Үүнд:

- Хүн амын өсөлт, орлого, хотжилт зэрэг нь хүнсний эрэлтийг хүмүүсийн хоолны дэглэмийг илүү их нөөц ихтэй амьтны гаралтай бүтээгдэхүүнд хандуулна.
- Ядуурал, тэгш бус байдал, ажилгүйдэл нь хоол, хүнсний хүртээмжийг хязгаарлаж хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн зорилгод хүрэхэд саад учруулна.
- Газар, усны нөөцийн чанар муудаж байгаа нь хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг хязгаарлана.
- Уур амьсгалын өөрчлөлт ургац болон хөдөөгийн амьжиргаанд төдийгүй эдийн засагт бүхэлд нь улам их нөлөөлж, хүлэмжийн хийг ялгаруулсаар байна.

² The future of food and agriculture – Alternative pathways to 2050

15) Эдийн засаг, менежментийн зөвлөх үйлчилгээг олон улсын түвшинд гүйцэтгэдэг McKinsey компанийн мэдээлж байгаагаар “Хөдөө аж ахуйн хөгжилд дараах 4 чиг хандлага гүнзгий нөлөөлөх төлөвтэй байгаа тул салбарынхан цаашдын төлөвлөлтөндөө анхаарч ажиллах ёстой”³ гэж зөвлөж байна. Үүнд:

1. Хүмүүсийн хооллох, ундлах хэв маягийн өөрчлөлт: уургийн хэрэглээ нэмэгдэж, хөгжиж байгаа орнуудын уургийн хэрэглээ хөгжингүй орны түвшинд хүрч, харин аль алинд нь таргалалтын эсрэг тэмцэл өрнөж байна. Энэ байдал үргэлжилж, уураг өндөртэй бүтээгдэхүүний хэрэгцээ нэмэгдэж болзошгүй.
2. Хоол хүнсээ хаанаас авах тухай бодлого: уурь амьсгалын өөрчлөлтийн нөлөө, эрчим хүчний зардал багатай газраас авах талаар боддог болно.
3. Хөдөө аж ахуйн технологийн дэвшил нь нэмүү өртгийн сүлжээнд ил тод байдал, хяналтыг нэмэгдүүлэх болно. Энэ нь үр ашгийг нэмэгдүүлж, хог хаягдлыг бууруулж, ашгийн хэмжээг багасгахад хүргэж болзошгүй.
4. Худалдааны дүрэм, гэрээ хэлэлцээрүүд: Засгийн газрын хөндлөнгийн оролцоо, татаас нь зах зээлийн динамикийг өөрчилж, дэлхийн худалдаанд урт хугацааны нөлөө үзүүлэх боломжтой.

16) Дэлхийн органик хөдөө аж ахуй 2022 тайлан⁴-гаас харахад органик хөдөө аж ахуйн салбар жилээс жилд өргөжиж 2020 оны байдлаар дэлхийн 187 оронд органик үйлдвэрлэл, худалдаа эрхэлж байгаа ба нийт хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 1.5%-ийг эзэлж байна. Органик зах зээлийн 90% нь АНУ, Европын холбоонд ноогдож байгаа ба БНХАУ, БНСУ, Энэтхэгт органик үйлдвэрлэл улам бүр чухал болж байгаа тухай энэ тайланд дурьджээ. Органик хүнсний нэг хүнд ноогдох хэмжээгээр Дани, Швейцар, Люксембург улсууд тэргүүлж байна.

Covid-19 цар тахлын үр нөлөөгөөр халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын үр нөлөөг бууруулах нь хүн төрөлхтөний нэн чухал зорилт болж байгаа энэ цаг мөчид хүмүүсийн эрүүл мэнддээ илүү анхаарах зан үйл илүү тодорч улмаар органик хэрэглээ нэмэгдсэн тухай тайланд дурьджээ. Гэхдээ органик сонголтыг хийж байгаа шалтгаан янз бүр байна. Зарим хүмүүс органик хүнсийг илүү эрүүл гэж боддог бол Дани болон Франц улсад хүмүүс органик худалдан авалтыг хүрээлэн буй орчноо хайрлах зорилготой, Герман улсад малын ая тухтай байдалд их анхаардаг тул органикийг сонгож байна, харин АНУ-д генетикийн өөрчлөлттэй бүтээгдэхүүнээс сэргийлж органикийг сонгож байна. Харамсалтай нь органик үйлдвэрлэлийн зориулалттай газар нутаг нэмэгдэж байгаа хэдий ч нийлүүлэлт нь эрэлтээ гүйцэхгүй байна.

Органик бүтээгдэхүүний импортын тоо, мэдээг Европын холбоо гаргаж байгаа ба органик бүтээгдэхүүний импорт ЕХ-нд өссөөр байна. Нидерланд, Герман, Бельги улсууд органик бүтээгдэхүүний гол импортлогч улсуудын тоонд багтаж байна.

³ Agriculture sector: Preparing for disruption in the food value chain. May 11, 2020 | Article By Mikael Djanian and [Nelson Ferreira](#)

⁴ The World of Organic Agriculture 2022, published by the Research Institute of Organic Agriculture FiBL and IFOAM

Улс орны засгийн газрууд агроэкологийн талаар тодорхой, зарим нь амбицтай бодлогыг баримталж байгааг доорх хүснэгтээс харах боломжтой.

Органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 2020 онтой харьцуулбал 15%-иар өссөн дүнтэй байна.

Хүснэгт. Дэлхийн хэмжээнд органик хууль тогтоомж хэрэгжсэн байдал

Бүс нутаг	Органик хууль тогтоомжийн хэрэгжилт	Улс орны тоо
Африк тив	Бүрэн хэрэгжсэн	1
Нийт-10 улс	Бүрэн хэрэгжээгүй	4
	Боловсруулагдаж байгаа	5
	Бүрэн хэрэгжсэн	11
Ази тив-26 улс	Бүрэн хэрэгжээгүй	9
	Боловсруулагдаж байгаа	6
	Бүрэн хэрэгжсэн	42
Европ тив-46 улс	Бүрэн хэрэгжээгүй	4
	Бүрэн хэрэгжсэн	16
Латин америк-21 улс	Бүрэн хэрэгжээгүй	3
	Боловсруулагдаж байгаа	2
	Бүрэн хэрэгжсэн	2
Хойд америк-2 улс	Бүрэн хэрэгжсэн	2
Австрали тив-4 улс	Бүрэн хэрэгжсэн	4

Эх сурвалж: IFOAM-ын 2022 оны судалгаа.

Дээрх хүснэгтээс харахад дэлхий дахинд нийт 76 улсад органик хууль тогтоомж бүрэн, 20 улсад хагас хэрэгжиж байна. 13 улсад органик хууль тогтоомж боловсруулагдаж байгаа ба Монгол Улс бүрэн хэрэгжсэн 76 улсын тоонд багтаж байна.

Монгол улсаас экспортолж байгаа ХАА-н гаралтын хүнсний бүтээгдэхүүнийг органик болгоход хамаг анхаарал, хүчин чармайлтыг гаргах замаар хүнсний бүтээгдэхүүний экспортын орлогыг 10%-100% нэмэгдүүлэх боломж байна.

Үүний тулд БНХАУ-ын CNCA байгууллагад хандаж, Монгол Улсын органик үйлдвэрлэл, баталгаажуулалтын тогтолцоог дүйцүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх талаар төлөвлөгөө гаргаж ажиллах нь зүйтэй байна.

Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Органик хүнс үйлдвэрлэлийн тэмдэг, схемийг Монгол Улсад хэрэглэх эрхийг авах, баталгаажуулах хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар бодох хэрэгтэй байна.

17) Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн зах зээлийн байдалд тулгуурлан НҮБХААБ-ын баримталж байгаа бодлоготой уялдуулан ижил төстэй хөгжлийн баримжаатай улс орны дээр туршлагад тулгуурлан дараах дүгнэлтийг гаргаж байна:

1. Хүнсний эрэлт, хэрэгцээ нэмэгдсэн хэвээр байна;
2. Газар, усны нөөцийн чанар муудаж байгаа нь хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг хязгаарлаж байна;
3. Уур амьсгалын өөрчлөлт ургацын хэмжээ, хөдөөгийн амьжиргаанд төдийгүй Монгол улсын эдийн засагт бүхэлд нь улам их нөлөөлж, хүлэмжийн хийг ялгаруулсаар байна;
4. Хүнс, хөдөө аж ахуйн зах зээл, гадаад худалдааг хөгжүүлэх нь Монгол улсын хөгжлийн тэргүүлэх чиглэл, гарц байна;
5. Дижитал технологи нь малчид, тариаланчдыг нэмүү өртгийн сүлжээнд оролцуулах боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;
6. Бусад улс орнуудад органик бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байна;
7. Монгол Улсад органик хөдөө аж ахуй үйлдвэрлэлийг экспортын хамт дэмжих замаар экспортын тоо хэмжээг нэмэгдүүлэх боломжтой байна.
8. Хөдөө аж ахуйн салбарын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломж байна.

III. Монгол Улсын хүнсний бүтээгдэхүүний экспортын багтаамжийн тухайд

18) Монгол улсад хүн амаа шим тэжээлээр тогтвортой хангаж чадах хоол хүнс үйлдвэрлэх хэрэгцээ шаардлага байна. Энэ нь хүмүүсийг аюулгүй, шим тэжээлтэй, боломжийн өртөгтэй хоол хүнсээр хангах хүнсний тогтолцоонд хөрөнгө оруулах; газар, ус болон бэлчээрийн чанарыг хадгалж, дээшлүүлэх, цаг уурын өөрчлөлтийн нөлөөллийг багасгах, биологийн төрөл зүйлийн хомсдлыг зогсоох хэрэгтэй гэсэн зорилтуудыг цогцоор авч үзэхийг шаардаж байна.

НҮБ-ийн ХХААБ-ын шинжээчдийн зөвлөж байгаагаар Монгол Улсын Засгийн газраас шим тэжээлт хоол хүнсэнд тэргүүлэх чиглэлээ хандуулж буй хөтөлбөр болон бодлогын хэрэгжилтэд хөрөнгө оруулж, тогтвортой хүнсний тогтолцоог бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна. Хүнсний үйлдвэрүүд бүтээгдэхүүний шим тэжээлт чанарыг сайжруулах шинэлэг санаачилгыг нэвтрүүлж, малчид, тариалан эрхлэгчид нь шим тэжээлт, төрөл

зүйлээр баялаг хүнсийг үйлдвэрлэхэд анхаарч, өлсгөлөнгүй дэлхийг бодитоор бий болгоход анхаарал хандуулахыг санал болгож байна.

19) Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг хүнсний хангамж, хүнсний хүртээмж, хүнсний илчлэг, шим тэжээл, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал гэсэн дөрвөн үзүүлэлтээр гаргаж байна. Хавсралт 8-д экспортын бүтээгдэхүүний багтаамжийн тухай мэдээллийг дэлгэрэнгүй оруулсан.

Монгол улсын хүн амын хүнсний гол нэрийн 16 бүтээгдэхүүний зохистой хэрэгцээг 2020 оны байдлаар тооцож үзвэл, улсын хэмжээнд жилд нийтдээ 182.4 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 153.6 мянган тонн сүү, 172.8 мянган тонн сүүн бүтээгдэхүүн, 96.0 мянган тонн гурил, 172.8 мянган тонн гурилан бүтээгдэхүүн, 115.2 мянган тонн төмс, 38.4 мянган тонн буурцагт ургамал, 192.0 мянган тонн жимс, жимсгэнэ, 22.1 мянган тонн ургамлын тос, 9.6 мянган тонн цөцгийн тосны хэрэгцээтэй байна.

Статистик тоо баримтаас харвал бид гол нэрийн бүтээгдэхүүн болох мах, сүү, гурил, төмсний хэрэгцээгээ хангаж, экспортлох нөөц байна. Мөн малын дайвар бүтээгдэхүүнийг экспортлох нөөц хангалттай байна.

IV. Экспортын замын зураг

20) Монголоос хүнс экспортлохыг дэмжих зорилго бүхий олон төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд хүнсний бүтээгдэхүүний экспортын “Замын зураг”-ийг боловсруулж гаргасан байна. Мөн, худалдаа хийх таатай орчинг худалдаа эрхлэгчдэд бүрдүүлж өгөх, экспорт, импортын баримт бичгийн бүрдүүлэлт хамгийн хямд зардлаар хурдан шуурхай, шударга, илүү ил тод болж, урьдчилан таамаглах, боловсруулалт хийх боломжтой болгох зорилгоор Монгол Улсын Гадаад худалдааны үндэсний мэдээллийн <https://mongoliatradingportal.gov.mn> портал сайт хөгжүүлэх төслийг Гадаад харилцааны сайд, Монгол Улсын Гаалийн газрын даргын ивээл дор хэрэгжиж буй Монгол Улсын Худалдааг хөнгөвчлөх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байна. Энэхүү портал дээр экспортлогчдод монгол улсын нутаг дэвсгэр дээрх үйл ажиллагаанд зориулан шаардлагатай хууль, тогтоомжууд, эрх бүхий байгууллагуудын холбоо барих хаяг, Экспортын хөтөч цэсийг бий болгож дараах мэдээллийг өгсөн байна:

1. Гаалийн бүрдүүлэлт, горим
2. Экспортын татвар
3. Хориглосон, Хязгаарласан бараа
4. Экспортын тусгай зөвшөөрөл, лиценз, сертификат
5. Гарал үүслийн гэрчилгээ

Хүнсний бүтээгдэхүүнийг экспортлогч аж ахуйн нэгжүүд гадаад худалдаанд оролцохын тулд худалдааны түншээ олох нь эзгэтэй асуудал байдаг. Олон улсын худалдааны төвийн www.trademap.com дээр дэлхийн 183 орон гадаад худалдаанд оролцох эрх бүхий аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг өгсөн байна. Монгол улсын ийм мэдээлэл хүртээмжтэй биш байна.

Дээрх вебхуудсанд дараах мэдээллийг өгсөн байна. Гадаад худалдаанд оролцож байгаа импорт болон экспорт хийж байгаа компаниудын

- Нэр
- Хот, улс

-
- Худалдаанд оролцож байгаа бүтээгдэхүүний нэрс
 - Ажилтны тоо
 - Жилийн худалдааны эргэлт
 - Холбоо барих ажилтан
 - Вебхуудас
 - Утасны дугаар

Иймд, хүнсний экспорт хийх бүртгэлтэй, төрөл бүрийн лиценз зөвшөөрөл авсан ААН, байгууллагын нэгдсэн мэдээллийг бий болгож, олон улсын худалдааны төвийн дээрх вебхуудсанд байршсан байх нөхцлийг бүрдүүлж, монголоос хүнс худалдан авах сонирхолтой аж ахуйн нэгжүүдэд нээлттэй болгох шаардлагатай байна.

Бидний энэхүү ажлын даалгаварын хүрээнд судалсан бүх 27 улсуудын хүнс импортлодог, зөвшөөрөлтэй компаниудын мэдээлэл дээрх вебхуудсанд нээлттэй тул хүнс экспортлохоор зорьж байгаа аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр хангах зорилгоор <https://mongoliatradingportal.gov.mn/> дээр байршуулж, түүнийг ашиглах боломжийг олгох ажлыг даруй зохион байгуулахыг санал болгож байна.

Гадаад худалдааны үндэсний мэдээллийн портал дээр импортлогчийн шаардлага, гадаад улсын нутаг дэвсгэр дээрх арга хэмжээний талаарх зөвлөмж (улс орны онцлог, гааль хяналтын байгууллагуудын тавьдаг нийтлэг шаардлага гэх мэт), гадаадын импортлогчдын мэдээллийг оруулах шаардлагатай байна.

Энэхүү ажлын даалгаварын хүрээнд судалгааны баг зорилтот улсуудын экспортын замын зургийг гаргасныг Хавсралт 9-д танилцуулж байна.

V. Хүнсний хууль эрх зүйн хорооноос гаргасан стандартын сан

21) Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй САС-ын нийт 93 стандарт байгаагаас 54 нь олон улсын түвшинд хэлэлцэгдэн ямар нэгэн нэмэлт өөрчлөлт орсон байна. Эдгээр стандартыг хянаж, шинэчлэн батлах шаардлагатай байна. Эдгээрийн дийлэнх нь дор хаяж 10 жилээр хоцрогдолтой байна. [Хавсралт 1.](#)

ХХЭЗХ-ноос хүчингүй болгож, стандартын сангаас устгасан 20 стандартыг бид одоог хүртэл хэрэглэж байна. [Хавсралт 2](#)-т харуулав

Хүнсний аюулгүй байдлыг хангах болон экспортын үйл ажиллагаанд шаардлагатай зайлшгүй орчуулж нутагшуулах шаардлагатай ХХЭЗХ-ноос гаргасан 72 стандарт байна. [Хавсралт 3](#)-т танилцуулав.

Мөн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нийт стандартад үзлэг хийж, орчуулгын алдаатай стандартыг дахин хянах шаардлагатай.

Хүнсний аюулгүй байдал, дотоодын хүнсний үйлдвэрлэлийг сайжруулж экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортоор орж ирж буй хүнсний бүтээгдэхүүнд тавигдах хяналтад олон улсын жишигт нийцсэн зөвлөмж стандартыг нутагшуулж хэрэгжүүлснээр хэрэглэгчдийн хүнсний аюулгүй байдлыг хангахад нэн чухал ач холбогдолтой. Иймд ДХБ байгууллагаас хэрэглэхийг уриалдаг Кодексийн стандарт, арга

зүйн заавар зөвлөмж, дадлуудыг аль болох нутагшуулж үндэсний стандарт болгох шаардлагатай байна.

Кодексийн стандарт нь заавал мөрдөх бус зөвлөмж хэлбэртэй байдаг ч улс орнууд үндэсний стандартаар баталснаар түүний хэрэгжилтийг хангаж, улмаар ДХБ-ын гишүүн бусад улс орнуудтай гадаад худалдаанд оролцох үед худалдааг хөнгөвчлөж саад тотгорууд багасах юм.

22) Монгол Улс нь ДХБ-аас хүлээн зөвшөөрөгдсөн Дэлхийн малын эрүүл мэндийн байгууллага буюу OIE, ДЭМБ болон ХХААБ нарын хамтарсан Хүнсний хууль эрх зүйн хороо буюу CODEX Alimentarius Commission, Олон улсын ургамал хамгааллын конвенц буюу IPPC гэсэн гурван стандарт тогтоох байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хэрэгжүүлж байх нь нэн чухал ач холбогдолтой юм. Цаашлаад хүнсний аюулгүй байдлын тухай Кодекс (Codex), малын эрүүл мэндийн талаарх (OIE) ДЭМБ, ургамлын эрүүл мэндийн талаарх IPPC-ийн олон улсын стандартыг нутагшуулж үндэсний стандартыг тэдгээртэй нийцүүлэх, мөн Монгол улсын оролцоог нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

23) Монгол Улс ДХБ-ын Ургамал, эрүүл ахуй, хорио цээрийн хэлэлцээрийн дагуу хүнсний аюулгүй байдал, малын эрүүл мэнд, ургамлын эрүүл мэнд зэрэг асуудлаар үндэсний холбоо барих этгээд буюу Focal Point -ыг ажиллуулж, холбогдох асуудлаарх мэдэгдэл хүргүүлж, мөн олон улсын стандартад үндэсний саналыг тусгах, нутагшуулах, таниулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Одоогоор малын эрүүл мэндийн "OIE" (Дэлхийн малын эрүүл мэндийн байгууллага) болон ургамлын эрүүл мэндийн IPPC талаарх үндэсний Focal Point-ын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа ч сайжруулах шаардлагатай байна. Харин Кодекс буюу ХХЭЗХ-ны асуудлаарх ажлууд сүүлийн жилүүдэд орхигдсон байна.

24) Дэлхийн худалдааны байгууллага нь хүнсний нэмэлт, мал эмнэлгийн эм, пестицидийн үлдэгдэл, бохирдуулагч бодис, шинжилгээ, дээж авах арга, эрүүл ахуйн дүрэм, дадлын дүрэм, зааврыг Codex Alimentarius Комисс (ХХЭЗХ)-оос тогтоосон стандарт, заавар, зөвлөмжийг хэрэглэхийг тусгайлан тодорхойлж, цохон тэмдэглэсэн байдаг. Энэ нь Кодексийн стандартыг шинжлэх ухааны үндэслэлтэй гэж үзэж, үндэсний арга хэмжээ, зохицуулалтыг үнэлэх жишиг хэмжигдэхүүн болгон хүлээн зөвшөөрдөг гэсэн үг юм. ДХБ-ын гишүүн улс орнууд Кодексийн стандартыг нутагшуулснаар экспорт импортын үед талууд эрх тэгш шударга өрсөлдөх боломж нээгдэж, худалдаан дахь техникийн саад тотгор багасдаг. Үндэсний хэмжээнд Кодексийн үйл ажиллагааг чадавхжуулснаар импортын хүнсний аюулгүй байдал төдийгүй, экспортын баримжаатай үндэсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлд чухал ач холбогдолтой юм.

25) Ургамал, эрүүл ахуй, хорио цээрийн болон Худалдаан дахь техникийн саад тотгорын хэлэлцээрүүд нь улс орнуудын авч хэрэгжүүлж буй ариун цэвэр, ургамлын эрүүл ахуй болон бусад техникийн стандартууд худалдаанд саад учруулах эрсдэлийг багасгах буюу арилгахын тулд стандарт техникийн зохицуулалтыг олон улсын хэмжээнд уялдуулахын чухлыг хүлээн зөвшөөрч, гишүүдийг өөрсдийн нөөц боломжийн хүрээнд олон улсын стандартын байгууллагууд болон тэдгээрийн салбар хороодын үйл ажиллагаанд "бүрэн оролцох"-ыг уриалан дэмждэг. Энэ нь улс орнуудын ХХЭЗХ-ны асуудлаарх үйл ажиллагааг идэвхжүүлж, оролцоог нэмэгдүүлсэн.

Өнөөдөр ХХЭЗХ-ны стандартууд нь уялдуулах, нутагшуулах замаар олон улсын худалдааг хөнгөвчлөх эрх зүйн орчны салшгүй хэсэг болж байна. Кодексийн стандартууд нь SPS болон ТВТ аль ч тохиолдолд ДХБ-ын өмнө гарч буй худалдааны маргаанаас урьдчилан сэргийлж, шийдвэрлэхэд тусалдаг.

26) Монгол улс ХХЭЗХ-оос гаргасан нийт 387 стандартаас өнөөдрийн байдлаар 93 стандартыг үндэсний стандартаар баталсан байна. Гэвч үүнээс 54 нь олон улсын түвшинд хэлэлцэгдэн ямар нэгэн нэмэлт өөрчлөлт орсон байна. Эдгээр стандартын ихэнх нь 10 орчим жилээр хоцрогдсон тул хянаж, шинэчлэн батлах шаардлагатай байна. ХХЭЗХ-оос хүчингүй болгож, устгасан 20 стандарт, зөвлөмжийг бид одоог хүртэл хэрэглэж байна. (Хавсралт 14) Мөн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нийт стандартад үзлэг хийж, орчуулгын алдаатай стандартыг дахин хянах шаардлагатай. Хүнсний аюулгүй байдал, дотоодын хүнсний үйлдвэрлэлийг сайжруулж экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортоор орж ирж буй хүнсний бүтээгдэхүүнд тавигдах хяналтад олон улсын жишигт нийцсэн зөвлөмж стандартыг нутагшуулж хэрэгжүүлснээр хэрэглэгчдийн хүнсний аюулгүй байдлыг хангахад шинжлэх ухаанд суурилсан стандарт зөвлөмжийг хэрэглэх нь нэн чухал ач холбогдолтой. Иймд, ДХБ байгууллагаас хэрэглэхийг уриалдаг Кодексийн стандарт, арга зүйн заавар зөвлөмж, дадлуудыг аль болох нэмж үндэсний стандартаар батлах нь зүйтэй.

Төслийн ажлын даалгаварын хүрээнд дараах баримт бичгүүдийг орчуулж, хянуулан, үндэсний болгон батлуулах ажлыг зохион байгуулав.

CXG 91-2017 Principles and Guidelines for Monitoring the Performance of National Food Control Systems;

CXG 82-2013 Principles and Guidelines for National Food Control Systems;

CXG 20-1995 Principles for Food Import and Export Inspection and Certification;

CXG 26-1997 Guidelines for the Design, Operation, Assessment and Accreditation of Food Import and Export Inspection and Certification Systems;

CXG 27-1997 Guidelines for the Assessment of the Competence of Testing Laboratories Involved in the Import and Export Control of Food;

CXG 34-1999 Guidelines for the Development of Equivalence Agreements Regarding Food Imports and Export Inspection and Certification Systems;

CXG 89-2016 Principles and guidelines for the exchange of information between importing and exporting countries to support the trade in food.

27) Монгол улс Кодексийг хэрэгжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх, үндэсний чадавхийг нэмэгдүүлэхэд ХХЭЗХ-ны зүгээс хэрэгжүүлж буй чадавх нэмэгдүүлэх зорилготой улс орнуудад 2016 оноос эхлэн олгож байгаа тусламж СТФ2 төсөлд хамрагдах нь зүйтэй. Тус дэмжлэгийг тодорхой улс орнуудад олгохоор төлөвлөсөн бөгөөд Монгол улс багтсан байна. Энэ асуудлыг Кодексийн үндэсний зөвлөл нэн тэргүүнд авч хэлэлцэн зохих шаардлага, бичиг баримтыг бүрдүүлж, холбогдох судалгааг хийж ХХЭЗХ-нд хүргүүлэх шаардлагатай байна. (Хавсралт 14-СТФ2 хэсэг)

Хавсралт 14 Хүнсний хууль эрх зүйн хорооны стандартын сан

Дэлхийн худалдааны байгууллага болон гэрээ хэлэлцээрүүд болон Кодексийн оролцоо Хүнсний аюулгүй байдал холбогдох чиглэлүүд болон Кодексийн үүрэг зэрэг асуудлаар дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 14-ийн бүлгүүдээс харах боломжтой.

VI Мэдээллийн менежментийн талаар

28) “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Цахим засаглал”-ыг бий болгох зорилтын хүрээнд гадаад худалдааны <https://mongoliatradingportal.gov.mn/> платформыг бий болгож, бизнес эрхлэгчдэд олон мэдээлэл, үйлчилгээг түргэн, шуурхай хүргэх боломжийг бүрдүүлсэн байна. Энэхүү платформ дээр экспортолж байгаа бүтээгдэхүүний сорилтын үр дүн, техникийн хяналт, баталгаажуулалт, итгэмжлэлийн дараах мэдээллийг импортлогч орны холбогдох хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүд шийдвэр гаргахад нь дэмжлэг болох тул шаардлагатай тохиолдолд цаг алдалгүй харах боломжтой байхаар цаг тухайд нь байршуулж, байнга шинэчилдэг байх мэдээллийн менежментийн бодлогыг CXG 89-2016⁵ стандартын дагуу тодорхойлох шаардлагатай байна:

- a. Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагуудын мэдээлэл;
- b. Тохирлын үнэлгээний байгууллага (лаборатори, техникийн хяналт болон баталгаажуулалтын байгууллага)-ын итгэмжлэлийн хамрах хүрээ;
- c. Олон улсын болон үндэсний ур чадварын сорилтуудыг зохион байгуулсан тухай, болон лабораториудын оролцсон байдал;
- d. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулсан мал, амьтанд хэрэглэхийг зөвшөөрсөн эмийн жагсаалт.

29) Экспорт хийх явцад худалдааны шударга бус, зарчимгүй байдал гаргасан тохиолдлуудыг бүртгэх, судлах, мэдээлэх, хяналтын арга хэмжээнүүдийг тодорхойлж хэрэгжүүлэх, дахин давтагдахгүй байх талаар залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, нийтэд нээлттэй байлгах шаардлагатай байна. Эс бөгөөс Монгол Улсын гадаад худалдааны муу жишиг, туршлага бий болж, Монгол улсын хүнсний аюулгүй байдлын үндэсний хяналтын тогтолцоонд итгэхгүй байх, нэр хүнд унах нөхцлийг бүрдүүлж байна.

30) Монгол улсын тухайд харьцангуй давуу талтай Чацаргана жимс болон түүнээс гаргасан бүтээгдэхүүнийг экспортыг нэмэгдүүлэхэд гарч байгаа хүндрэлүүдийг Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх техникийн туслалцааны төслийн хүрээнд дараах байдлаар тодорхойлсон байна. Чацаргана жимсний экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд учруулж байгаа хамгийн том хязгаарлалт нь энэ талаар мэдээлэл өгөх албан ёсны байгууллага байхгүй тул гадаад зах зээлд нэвтрэх чадамж, төрийн бодлого зохицуулалт, дотооддоо боловсруулах хүчин чадал муу байна гэж үзжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт ...-д харуулав.

Мөн түүнчлэн Чацаргана жимсний БТКУС код байхгүй тул гадаад худалдаанд тодорхой бус байдлыг бий болгож байна.

⁵ CXG 89-2016 Хүнсний худалдааг дэмжих зорилготой импортлогч болон экспортлогч орнуудын хооронд мэдээлэл солилцох зарчим ба удирдамж

Цаашдаа Монгол улсын Кодексийн үйл ажиллагааг идэвхжүүлж улмаар ХХЭЗХ-ны Ази бүсийн хороонд олон улсын стандартын төсөл боловсруулж, батлуулах боломж байна.

Монгол Улсын нутагт ургадаг Хушны самрын эрэлт Европын холбоонд их байна. Ковид-19 цар тахлын шалтгаанаар БНХАУ Монголоос бүтээгдэхүүн импортлохыг зогсоосонтой холбоотой БНХАУ-аар дамжиж ЕХ руу гарч байсан хушны самрыг Монголоос шууд экспортлох таатай нөхцөл бүрдсэн байна. Энэ боломжийг бүрэн хэмжээнд ашиглахын тулд Байгаль орчны яамтай хамтран хушны самар түүх, боловсруулах үйл явцыг хэрэгжүүлдэг иргэн, аж ахуйн нэгжүүдэд тавих хяналтыг Хүнсний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дэлхийд эрэмбэлэгдэж байгаа хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих замаар экспортын хэмжээг

Адууны мах, дулааны боловсруулалт хийсэн хонь, ямааны мах, Рапс, гурвалжин будаа, Хушны самар

Хүнсний бүтээгдэхүүний улсын эдийн засагт мэдэгдэхүйц хувь нэмэр оруулах хэмжээнд экспортыг хөгжүүлэх бодлогыг бодитой болгоход энэ асуудлыг хариуцдаг, хянадаг, зохицуулдаг, асуудлыг дор бүрэн нь шийддэг эрх мэдэл бүхий нэгж юуны өмнө шаардлагатай байна. Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэх явцаас харахад монгол хүмүүс тодорхой түвшинд худалдаа хийх туршлага, чадвартай болсон байна, төрөөс зохицуулалтуудыг хийж байна, харин мэдлэг нэг дор цугларч, хэрэгтэй хүндээ хүрдэггүй, хүрсэн ч хэрэглэх арга мэддэггүй байх явдал түгээмэл байна.

Монголоос БНХАУ руу экспортолсон хүнсний бүтээгдэхүүний **89.7%** хувийг эзэлж байгаа тул бусад АНУ, БНСУ, Япон зэрэг улс орнуудын гадаад худалдааны асуудлыг хөгжүүлж байгаа туршлагын дагуу БНХАУ руу хүнс экспортлох асуудлыг хариуцсан алба, нэгж бий болгох замаар эдийн засагт мэдэгдэхүйц хувь нэмэр оруулах боломжтой байна.

Түүнчлэн БНСУ, Арабын улсууд, ОХУ, Япон улс руу хүнс экспортлох асуудал хариуцсан хүмүүсийг томилж, сургах, ААН, байгууллагуудад экспортыг худалдааны шударга зарчимуудын дагуу удирдахад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих ажлыг юун түрүүнд зохион байгуулахыг санал болгож байна.

VII. Импортлогч орнуудын шаардлага

Импортлогч улсууд үндэснийхээ аюулгүй байдал, төгтвортой хөгжлийн бодлогын хүрээнд ДХБ-ын хэлэлцээрээр хүлээсэн үүргийн дагуу Тарифын болон Тарифын бус зохицуулалтыг гаргаж импортоор орж ирж байгаа хүнсний бүтээгдэхүүнийг хянаж байна.

Тарифын зохицуулалт

30) Монгол Улсаас хүнсний бүтээгдэхүүнийг импортлоход тогтоосон тарифын зохицуулалтыг хүнсний бүтээгдэхүүний төрөл тус бүрээр гаргаж харьцуулахад дараах дүр төрх харагдаж байна. Тарифын хэмжээг улс орон тус бүр хүнсний бүтээгдэхүүний төрөл тус

бүрт ноогдуулж байгаа тарифын хэмжээг [Хавсралт 15](#)-д танилцуулав.

БНХАУ-ын тухайд дараах бүтээгдэхүүнд гаалийн татвар ноогдуулдаггүй:

- Амьд хонь, ямаа
- Овьёос
- Арвай
- Гурвалжин будаа
- Рапс
- Шар бууурцаг

Хивэг, Улаанбуудайн хивэгний татвар 3%,

- Үхрийн мах. Дайвар эсвэл цусаар хийж бэлтгэсэн эсвэл нөөшилсөн
- Ямааны мах. Дулааны боловсруулалт хийсэн
- Хиам, зайдас, бууз
- Үхрийн махан нөөшилсөн бүтээгдэхүүн
- Хонины мах, Дулааны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүнд 5%-ийн гаалийн татвар ноогдуулдаг байна.

Бусад бүтээгдэхүүнд 65% хүртэл татварыг ноогдуулж байна.

Дэлгэрэнгүйг Хүснэгт 15-1-д харьцуулсан хүснэгтээр харуулав.

Япон улсын тухайд Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол улс, Япон улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд монголын зөгийн бал, эмийн ургамал, сүүн бүтээгдэхүүнээс бусад нь татваргүй байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 15-2-т харьцуулсан хүснэгтээр харуулав.

БНСУ-ын тухайд Рапсын үрийг гаалийн татваргүй нэвтрүүлдэг, үхэр, хонь, ямааны боловсруулаагүй өөх, тосыг 3%, бусад бүтээгдэхүүнүүд 72% хүртэл татвартай байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 15-3-т харьцуулсан хүснэгтээр харуулав.

ОХУ-ын тухайд Хамгийн бага буюу 5% -ийн татвартай малын дайвар, улаан буудай, тэжээлийн буудай, арвай, эмийн ургамлыг ОХУ руу экспортлох боломжтой, харин бусад бүтээгдэхүүнүүд 20% хүртэл гаалийн татвартай байна.

Европын холбооны тухайд Европын холбооны GSP plus хөтөлбөрийн хүрээнд Монголоос экспортлох цэвэр зөгийн бал, сүүн бүтээгдэхүүн, хушны самарнаас бусад хүнсний бүтээгдэхүүн тарифын хөнгөлөлтөд хамрагдаж байна. Монголоос экспортлох боломж ихтэй хушны самар 2%-ийн татвартай байна.

Арабын орнууды тухайд

Амьд хонь, бог малын өлөн гэдэс, арвай зэрэг бүтээгдэхүүнийг гаалийн татваргүй оруулдаг бол Монгол Улсаас экспортлох боломжтой хүнсний бүтээгдэхүүнүүдэд Арабын орнуудын импортын татвар 5 хүртэл хувь байна.

Дүгнэлт: Худалдааны хөнгөлөлт эдэлж, өндөр хөгжилтэй Япон болон Европын холбооны улсууд руу хийх экспортын хэмжээг нэмэгдүүлэх боломжийг аль болох бүрэн ашиглах талаар илүү эрчимтэй ажиллах шаардлагатай байна.

АРТА - Ази, Номхон Далайн Худалдааны Хэлэлцээрт монголоос экспортлох боломжтой хүнсний бүтээгдэхүүний тарифын хөнгөлөлтийн асуудлыг тухайн бүтээгдэхүүний төрлөөр гаргаж, шийдвэрлүүлэх ажлыг хамруулах замаар тарифын саад тотгорыг шийдвэрлэх боломж байна.

АРТА-гийн хэлэлцээрийн хүрээнд БНХАУ нь 2323 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнд 10-100% тарифын хөнгөлөлт өгдөг. Монгол Улсаас экспортлох боломжтой Рапсын үрэнд 100% татварын хөнгөлөлтийг үзүүлж байна. Энэ жишгээр бусад хүнсний бүтээгдэхүүнийг хөнгөлөлтөд хамруулах шаардлагатай гэж үзлээ. Мөн БНСУ нь 2868 бараа бүтээгдэхүүнд 10-50% хүртэл тарифын хөнгөлөлт үзүүлдэг.

Иймд, гадаад худалдааны асуудал хариуцсан эрх бүхий байгууллагад экспортлох боломжтой хүнсний бүтээгдэхүүнийг АРТА-гийн хэлэлцээрийн хөнгөлөлтөд хамруулах талаар ХХААХҮЯ-наас хүсэлт гаргаж, хэрэгжүүлэхэд хяналт тавих ажлыг зохион байгуулахыг санал болгож байна.

Тарифын бус зохицуулалт

31) Импортлогчдын гаргасан Тарифын бус зохицуулалтуудыг харьцуулж, манай төрийн зүгээс хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний саналыг танилцуулж байна:

- (A) Эрүүл ахуй хорио цээр (SPS),
- (B) Худалдаан дахь техникийн саад тотгор (ТБТ),
- (C) Ачилтын өмнөх,
- (E) Квот, лиценз,
- (F) Үнийн хяналт,
- (N) Оюуны өмч.

Тарифын бус зохицуулалтын хүрээнд БНХАУ, Япон, БНСУ, ОХУ, ЕХ, Арабын улсууд дээрх ангиллын дагуу хүнсний бүтээгдэхүүний ангилал тус бүрт хамаарах ялгаатай шаардлагыг [Хавсралт 10](#)-т танилцуулав.

Улс орнууд хүнсний аюулгүй байдалд хамаарах дүрэм, журмаа өөр хоорондоо нийцүүлэхийн тулд САС (Хүнсний хууль эрх зүйн хороо)-ийн стандартыг ашигладаг. ДХБ-ын Амьтан, ургамлын эрүүл ахуйн (SPS) арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрт Codex стандартыг үндсэн баримтлах техникийн шаардлага болгосон. Иймд, Codex стандартуудын шаардлагыг хэрэгжүүлэх замаар улс хоорондын худалдааны саад тотгор, хүнд суртлыг багасгах боломж бидэнд байна.

32) Импортын шаардлагын **A)** ангилалд хамаарах эрүүл ахуй, ургамлын хорио цээр (SPS)-ийн тухайд мал, амьтан, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн экспортлогч улс нь Эмийн үлдэгдлийн хяналтын төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагын хуваарилалт, лабораторийн чадамж, аргын баталгаажуулалт, ур чадварын сорилтонд хамрагдсан байх, пестицидын хяналтын хөтөлбөртэй байх зэргийг шаардаж байна.

Монгол улсын эрүүл ахуй, ургамлын хорио цээр (SPS)-ийн салбар сүүлийн жилүүдэд багагүй сайжирч байгаа хэдий ч хүнсний бүтээгдэхүүнийг экспортлоход техникийн саад тотгорыг бий болгосоор байгаа тухай [ДХБ-ын ээлжит худалдааны дүн шинжилгээний тайлан](#)д дурьдсан байна. Тухайлбал, “..... эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн арга

хэмжээнүүд олон улсын стандартад бүрэн нийцээгүй, эрсдэлд суурилсан хяналт, шалгалт муу, зохицуулалт, туршилтын системд хөрөнгө оруулалт хийх, сайжруулах шаардлагатай байна.

Энэ байдал нь хүн амын дунд үндэсний үйлдвэрлэлээс илүү импортын хүнсний бүтээгдэхүүнд найдахад хүргэж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийг удаашруулж, экспортын боломжоо бүрэн ашиглаж чадахгүй байна...” гэж олон улсын гадаад худалдааны шинжээчид тодорхойлж байна.

33) Монгол Улсын хууль тогтоомжид 1997 онд батлагдсан Ургамал хамгааллын олон улсын конвенц (IPPC)-ийн Ургамал эрүүл ахуйн арга хэмжээний олон улсын стандартыг тусгаагүй байна. Хүнсний аюулгүй байдлын тухайд Хүнсний тухай хууль болон Кодекс буюу Хүнсний хууль эрх зүйн хорооны талаарх тодорхойлолтын зөрүү, эрсдэлд суурилсан үнэлгээ дутмаг байгаа нь тогтоогдсон. (CAREC/ADB, [Modernizing Sanitary and Phytosanitary Measures in CAREC: An Assessment and the Way Forward](#), May 2019.)

SPS-ийн арга хэмжээг Монгол улсад хэрэгжүүлж, улмаар сайжруулахтай холбогдсон үндэсний хэмжээний гол хуулиудад Амьтан, ургамал, түүхий эд, тэдгээрийн гарал үүсэлтэй бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх хорио цээрийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Амьтан, ургамал, түүхий эд, тэдгээрийн гарал үүсэлтэй бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх хорио цээрийн дэглэм, хяналт шалгалтын тухай хууль, Ургамал хамгааллын тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль зэрэг орно. Эдгээр хуулиудын дийлэнх нь багагүй хэмжээнд шинэчилсэн найруулгад орсон, үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд нь хэвээр үлджээ. (Хүснэгт)

Хүснэгт.....: SPS арга хэмжээтэй холбогдох гол хуулиуд

Холбогдох хууль тогтоомж	Хураангуй	Огноо
Амьтан, ургамал, түүхий эд, тэдгээрийн гарал үүсэлтэй бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх хорио цээрийн дэглэм, хяналт шалгалтын тухай хууль	Олон улсын хилээр нэвтэрч буй бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтыг зохицуулдаг	2002/11/28
Малын эрүүл мэндийн тухай хууль	Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан малын эрүүл мэндийг хамгаалах зохицуулалт	2017/12/08
Ургамал хамгаалах тухай хууль (Шинэчилсэн найруулга)	Ургамлын өвчин, хортон шавьж гэх мэтээс ургамлыг хамгаалах, хянах, хорио цээрийн дэглэм тогтоох	2007/11/15
Баяжуулсан хүнсний тухай хууль	Зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг амин дэм, эрдэс бодисоор заавал үйлдвэрлэлийн баяжуулах, түүний дотор импортлох, үйлдвэрлэх, экспортлох, агууламжийг хянах.	2018/05/03
Хүнсний тухай хууль	Хүртээмжтэй, чанартай, шим тэжээлтэй, аюулгүй хүнсний асуудлыг зохицуулдаг	2012/12/20

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль	Хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай	2012/12/20
Органик хүнсний тухай хууль	Органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, баталгаажуулалт, худалдах, импортлох, ашиглах, тэмдэг хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулна	2016/04/07
Малын генетик нөөцийн тухай хууль	Мал, тэжээвэр амьтдын удамшлын нөөцийг бүртгэх, таних, хадгалах, хамгаалах, зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.	2017/12/14
Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн журам; Эрсдэлийн үнэлгээний журам	Төв лаборатор; Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн чиг үүргийг тогтоох; хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийн мэдээллийн сангийн удирдлагыг хангах; эрсдэлийн үнэлгээний багийн журмыг бий болгодог	2013/10/05
Эрсдэл ихтэй хүнсний бүтээгдэхүүнийг импортлоход ачихаас өмнөх хяналт шалгалтын журам	Өндөр эрсдэлтэй хүнсний бүтээгдэхүүний импорын асуудлаарх;	2013/10/12

34) Монгол улсын Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль нь хүнсний аюулгүй байдлын үндсэн хүрээг бүрдүүлдэг. Хүнсний тухай хуульд хүнсний бүтээгдэхүүн импортлогч, экспортлогч нь Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх; импортын хүнсний бүтээгдэхүүн нь сайн туршлагыг ашигласан эсвэл HACCP системийг дагаж мөрдсөн гэх гэрчилгээтэй аж ахуйн нэгжийнх байх; Хувиргасан амьд организмаар хийсэн импортын хүнсийг зохих ёсоор бүртгүүлээгүй тохиолдолд хориглоно; импортын хүнсний бүтээгдэхүүний хадгалах хугацааны гуравны хоёроос доошгүй нь хүчинтэй хэвээр байна гэх мэт SPS арга хэмжээтэй холбогдох заалтууд тусгагдсан.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуульд HACCP-ыг хэрэгжүүлэх, эрүүл ахуйн эсвэл хөдөө аж ахуйн зохистой дадлыг хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн бүх үе шатанд үйлдвэрлэлийн зохистой дадлыг хангах зэрэг хүнсний сүлжээн дэх аюулгүй байдлын арга, хэрэгслийг заасан. Гэтэл Монгол Улсад HACCP-ын шаардлагыг тогтоосон баримт бичиг байхгүй тул CAC RCP 1:2003 стандартын дагуу баталгаажуулалтыг хийхэд хүргэж байгаа тул импортлогчид хүлээн зөвшөөрөх боломжгүй байна. Иймд, дээрх хуулинд заасан HACCP, зохистой дадлуудыг хэрэгжүүлэх хялбаршуулсан заавруудыг даруй боловсруулж, батлан, хэрэгжилтийг хангуулбал импортлогчдын SPS болон TBT-ийн шаардлагыг хангах нөхцөл бүрдэнэ.

Тайланд улсын жишээг харахад HACCP-ын зарчмыг тодорхойлосон СХС 1-1969 стандартыг хууль болгон улсдаа хэрэгжүүлснээр өдгөө 25 жилийн дараа үр шимийг нь

хүртэж байна: хүнсний аюулгүй байдлын асуудлаа дотооддоо шийдвэрлэж, мөн өрсөлдөх чадвартай хүнс экспортлогч болж чадсан байна.

35) “Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн дагуу Ургамал хамгаалахад ашиглах ургамал хамгааллын бодис импортлох, борлуулах үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлж байна. Улсын хэмжээнд пестицидын шинжилгээг гүйцэтгүүлэхээр 2 лаборатори итгэмжлэгдсэн байна: МХЕГ-ын ХАБҮЛЛ болон Ургамал хамгаллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Пестицидийн лаборатори.

Малын эмнэлгийн ариун цэврийн арга хэмжээний тухайд 2023 он хүртэлх “Малын эмийн үлдэгдлийн хяналт” Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

SPS-ийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа хэдий ч ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэлэмжийг нэмэгдүүлж, экспортлохын тулд **ургамал, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд пестицидийн үлдэгдлийг хянах хөтөлбөрийг** даруй боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

36) Монголын зөгийн балыг Япон болон Европын холбоо руу экспортлох сонирхолтой байгаа тул зөгийн балны экспортыг дэмжих зорилготой төрөл бүрийн төслүүдийн хүрээнд эрх зүйн орчин бий болсон байна. АХБ-ны санхүүжилтээр хийсэн “Монголын зөгийн балыг Европын холбооны орнуудад экспортлох боломжид судалгаа хийж, дэмжлэг үзүүлэх” 2020/В/05 судалгааны ажлын тайланд дүгнэж хэлснээр “... Монгол улсад мөрдөж буй мал, амьтнаас гаралтай хүнсний бүтээгдэхүүний тухай хууль эрх зүйн баримт бичгүүд нь олон улсын хүнсний аюулгүй байдлын хүрээнд мөрддөг дүрэм журмууд дээр суурилж боловсруулж батлуулсан байдаг учраас өндөр хөгжилтэй орнуудын Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, заавраас нэг их зөрөөд байх юм байдаггүй. Хамгийн гол асуудал нь эдгээрийн хэрэгжилт, дүрэм журмууд хэрэгжиж байгааг батлах нотлох **хяналтын тогтолцоо хязгаарлагдмал** байгаа юм. Тийм ч учраас өнөөг хүртэл Монгол улсаас ХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүний экспортын худалдаа дорвитой хэмжээнд хүрч чадахгүй байсаар байна.”

37) Монгол Улс Ойрх дорнодын улсууд руу мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох боломжийн талаар 2020 онд UNIDO-гоос хийсэн Булангийн орнуудын мах, малын дайвар бүтээгдэхүүнд тавих импортын шаардлагын судалгааны тайлангаас харахад Халал баталгаажуулалтыг хийлгэсэн байх нь зайлшгүй шаардлага болж байна. Халал бүтээгдэхүүнд тавих шаардлага нь мусулман шашинтай улс орнуудад харилцан адилгүй байдаг тул бид Халал баталгаажуулалтыг хэрэгжүүлэхэд Булангийн орнуудын стандартчиллын байгууллага (GSO)-аас баталсан стандартуудын ашиглах нь зүйтэй байна. Иймд, Монгол Улс экспортын нөөцтэй бог малаа Булангийн орнуудын шаардлагын дагуу Халал баталгаажуулалт хийж экспортлох талаар зохих арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж эхлэх хэрэгтэй байна.

38) САС GL 82-2013 стандартын 58-д “... Хүнсний хяналтын үндэсний хөтөлбөрүүдийн бодит, хараат бус байдлыг алдагдуулахгүйгээр зорилгодоо хүрэх боломжийг бүрдүүлэхийн тулд эрх бүхий байгууллага, түүний нэрийн өмнөөс нийцлийн болон хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг эрхэлж буй эрх бүхий байгууллага нь хангалттай нөөцтэй, ил тод байвал

зохино. Хөндлөнгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагад хүнсний хяналтын үндэсний тогтолцоог хэрэгжүүлэх зөвшөөрөл ба/эсвэл эрх олгосон байж болох ба эрх бүхий байгууллага нь тэдгээрийг хянах чадвартай байна” гэж заасны дагуу мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллага эсвэл хувийн хэвшлийн байгууллага гэрээний үндсэн дээр гүйцэтгэх боломжтой юм.

Иймд, хүнсний хяналтын үндэсний тогтолцоог удирдахад шаардлагатай итгэмжлэгдсэн хүнсний сорилт, туршилтын лабораториуд, техникийн хяналтын болон баталгаажуулалтын байгууллагууд зэрэг “хөндлөнгийн үйлчилгээ үзүүлдэг” байгууллагуудыг томилж, гэрээ байгуулж, бохирдуулагч бодисын үлдэгдлийн болон пестицидийн хяналтыг хэрэгжүүлэх саналыг танилцуулж байна. Тухайлбал, Пестицидийн үлдэгдлийн мониторинг хийхэд пестицидийн үлдэгдлийг шинжлэхээр итгэмжлэгдсэн лабораториудаар гүйцэтгүүлэх гэрээ байгуулж ажиллах нь зүйтэй байна.

39) Ковид 19-ийн цар тахал улс орнуудын хүнсний импортод тавих шаардлагыг улам чангатгахад хүргэсэн.

Хүнс, ХАА-н гаралтай бүтээгдэхүүнийг экспортлохын тулд Арабын улсууд, ЕХ зэрэг импортлогч улсад тухайн улс орны хүнсний хяналтын тогтолцооны талаар мэдээлэлд үндэслэж бүртгүүлсэн байхыг шаардаж байна. Мөн импортлогч орнуудад экспортлогч ААН нь бүртгүүлсэн байхыг шаардаж байна. Иймд, төрийн эрх бүхий байгууллага холбогдох журмын дагуу хүсэлт гаргаж, бүртгүүлэх шаардлагатай байна.

40) Импортлогч улсын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан байлгахын тулд импортлогч орны холбогдох стандарт, норматив баримт бичигт заасан сорилтын арга аргачлал, сорилтын төрлүүдээр итгэмжлэгдсэн лабораториудыг бий болгох тал дээр тохирлын үнэлгээний бодлогын асуудал төрийн захиргааны байгууллага нь энэ мэдээллийг нэгтгэж боловсруулж хүнсний лабораториудад чиглэл өгч ажиллах шаардлагатай. Энэхүү судалгааны хамрах хүрээнд импортлогчдын шаардлагыг энэхүү тайлангийн Хавсралт 10-т гаргав.

Тухайлбал: Европын холбоонд мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнд үлдэгдлийг хянах төлөвлөгөөнд итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийхээр тусгасан тохиолдолд LC/MS болон GC/MS аргуудаар шинжилгээг хийж, аргыг баталгаажуулж Үлдэгдлийг хянах төлөвлөгөөний шинжилгээний тухай мэдээллийн хэсэгт тэмдэглэж оруулна. Тухайлбал, ЕХ руу экспортолж буй зөгийн баланд ямар ч антибиотикийн үлдэгдэл байх ёсгүй ба хэрэв ЕХ-ны үнэлгээний багаас зөгийн аж ахуйд малын эмийн хэрэглээ ихтэй, антибиотикийн үлдэгдэл байх эрсдэл өндөр гэж дүгнэвэл антибиотикийн болон малын эмийн шинжилгээ хийхийг шаардаг.

41) Улс орнуудын хүнс импортлоход тавьж байгаа шаардлагыг нарийвлан судалж үзэхэд үндсэндээ экспортлогч улсын хүнсний хяналтын тогтолцоо бүрдсэн байхыг л шаардаж байна. Экспортлогч улсын төрийн байгууллага нь экспортлож байгаа бүтээгдэхүүн тус бүрийг нэг ёсондоо батлан даах ёстой гэж шаардаж байна. Тухайлбал, импортлогч нь экспортонд гаргаж байгаа хүнсний бүтээгдэхүүний гарал үүслээс, улсын хил нэвтрэх хүртэл сүлжээнд оролцогч бүх тал бүртгэлтэй, тодорхой шаардлагыг хангасныг экспортлогч улс буюу төр нь мэддэг байхыг л шаардаж байна.

Хүнсний хяналтын үндэсний тогтолцооны зарчим, удирдамж CAC/GL 82-2013 стандартад “Хүнсний хяналтын үндэсний тогтолцооны зорилго нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах,

хүнсний худалдаанд шударга байдлыг хангахад оршино” гэж заасан. Хоол хүнс нь хүний эрүүл мэндэд тустай байх асуудлыг ЭМЯ нь хариуцдаг, ХХААХҮЯ нь хүртээмжийг хариуцаж, хүнсээр дутагдахгүй байхад гол анхаарлаа хандуулж байна. Гэтэл САС/GL 82-2013 стандартад Хүнсний хяналтын тогтолцооны хамгийн эхний зарчим бол “Хэрэглэгчийг хамгаалах” зарчим байх ёстой гэж заасан.

Дээрх стандартад тогтоосон Ил тод байх тухай 3-р зарчмыг бид дутуу л хангаж байна. Цахим үндэстэн болох бодлогын хүрээнд олон зүйлийг цахимжуулж байгаа хэдий ч хүнсний аюулгүй байдлын талаарх мэдээллийг цахимжуулаагүй. Хүнсний аюулгүй байдлын итгэмжлэгдсэн лаборатори, мэргэжлийн хяналт, баталгаажуулалтын байгууллага хоорондын уялдаа байхгүй, мэдээллийг нэг дороос авах боломжгүй байна.

БНХАУ-д улсынх нь хил нэвтэрч байгаа бүх хүнсний бүтээгдэхүүний талаарх мэдээллийг цаг тухайд нь авах боломжтой байдлаар цахимжуулсан байна.

ОХУ-д тохирлын баталгаажуулалт хийлгэсэн бүтээгдэхүүний гэрчилгээг нэг дороос харах боломжтой байдаг.

Иймд, Монгол Улсын хүнсний хяналтын тогтолцоог ХХААХҮЯ нь тохирлын үнэлгээ (сорилт, туршилт, мэргэжлийн хяналт, баталгаажуулалт)-ний талаарх бодлогыг тодорхойлж, мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэхээр томилж, тэдгээр тохирлын үнэлгээний байгууллагын чадавхийг Итгэмжлэлийн байгууллагаар тогтоолгох байдлаар бүрдүүлж, Хүнсний хяналтын үндэсний тогтолцооны зарчим, удирдамж САС/GL 82-2013 шаардлагад нийцүүлэх шаардлага гарч ирж байна.

Хавсралт 1. Экспортын баримжаатай хүнсний бүтээгдэхүүнийг тодорхойлох аргачлал

Экспортын баримжаатай хүнсний бүтээгдэхүүнийг тодорхойлох үйл ажиллагаанд Олон улсын худалдааны төв (ИТС)-ийн мэрэгжилтэн, шинжээчдийн боловсруулсан экспортын чадавхийг хөгжүүлэх үнэлгээний дараах арга зүйг ашигласан:

1. Монгол улсаас экспортлох боломжтой бүтээгдэхүүний зорилтот зах зээлүүд;
2. Зорилтот зах зээл дэх эрэлт, нийлүүлэлтийн байдал;
3. Зорилтот зах зээлд нэвтрэхэд хялбар байдал,
4. Зорилтот зах зээлд нийлүүлэлтийн төвөгтэй байдал;
5. Зорилтот зах зээл дээрх тухайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар.

Экспортын баримжаатай хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг тодорхойлохдоо дараах шалгууруудыг онцлон авч үзлээ. Үүнд:

1. Зорилтот орны хүнсний импортын хэрэгцээ ба хүлээлт;
2. Хүнсний зохистой хэрэглээ, аюулгүй байдлын талаарх дэлхийн чиг хандлага;
3. Монгол Улсын хүн амын хүнсний хангамжийн түвшин;
4. 2012-2021 оны хүнсний бүтээгдэхүүний экспортын сургамж;
5. Эдийн засгийн үр ашиг.

Монгол Улсаас сүүлийн 10 жил (2012-2021 он)-ийн хугацаанд экспортолсон хүнсний бүтээгдэхүүний судалгааг бүтээгдэхүүний ангилал, экспортын тоо хэмжээ, үнийн дүн, тээвэр ложистикийн арга, импортлогч орноор дараах эх үүсвэрийг ашиглаж гаргасан:

1. Монгол Улсын статистик мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn;
2. Монгол Улсын гадаад худалдааны мэдээллийн сан, <https://mongoliatradingportal.gov.mn/>;
3. Монгол Улсын Гадаад худалдааны барааны статистик мэдээ, <https://gaali.mn/statistic>;
 4. Олон улсын худалдааны төв (ИТС)-ийн гаргасан <https://www.trademap.org/>;
 5. НҮБ-ын Хүнс, ХАА-н статистик мэдээ <https://www.fao.org/faostat/>;
 6. Монгол Улсаас экспортлох боломжтой хүнсний бүтээгдэхүүний талаар дараах мэргэжлийн холбоодын мэргэжилтнүүдтэй ажил хэрэгч уулзалтууд зохион байгуулж санал, зөвлөмжийг авлаа. Үүнд:
 - Монголын хүнсчдийн холбоо;
 - Монголын махны холбоо;
 - Монголын жимс, жимсгэний холбоо;
 - Монголын тариалан эрхлэгчдийн нэгдсэн холбоо;
 - Монголын зөгийчдийн нийгэмлэг;
 - Монголын Бяслал үйлдвэрлэгчдийн холбоо.

Судалгаа авч ярилцсан экспортлогч аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг доорх жагсаалтаар харуулав.

Хүснэгт. Судалгаа авч ярилцсан экспортлогч аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл

№	Байгууллагын нэр	Бүтээгдэхүүн
1	Ай Би Си Эко ХХК	"Түнхэл" нэрийн зөгийн бал
2	Боса Кондитор ХХК	"MONKONDI" нэрийн хатуу чихэр
3	Дархан мах ХХК	Үхэрийн мах, Адууны мах, (дөрвөлжин хөлдөөсөн мах) Хонины мах, Ямааны мах (гулууз)
4	Есөн Од Фүүд интернэшнл ХХК	70гр Сүүтэй шоколад, -Монгол хамгийн сайн шоколад
5	Гацуурт ХХК	440 Зөгийн бал
6	Жи Би Ти Трэйдинг ХХК	Мөөгтэй лечо, Алаг салат, "Артишок" эрүүл мэндийн ундаа, Дарсан өргөст хэмх
7	Жэм интернэйшнл ХХК	Хужирт цэвэр ус -330 мл, 700мл, Хужирт бөмбөлөгтэй ус-330 мл, 700мл, Хужирт цангистай ус -330мл, 700мл
8	Глобал Номадик Продактс ХХК	100% сарлагийн цэвэр сүү
9	Ингэн Тагш ХХК	"Tsagaan Doctor" ингэний хоормог
10	Живэртийн оргил ХХК	Чацарганы 100% цэвэр шүүс, Чацарганы 100% зутан тос, Чацарганы 100% үрийн тос
11	Хаан жимст Эс Би Ти ХХК	Чацарганы цэвэр жимс Чацарганы жимсний тослог нухаш
12	Хатансүйх Импекс ХХК	Үхрийн чанасан бүтээгдэхүүн, Үхрийн ясны ханд, Хиам, Утсан хиам
	Лакс Солюшн ХХК	"Pine nut" хуш самарны чөмөг
13	Монгод Маркет ХХК	"BEEF STEW" үхрийн жигнэсэн мах
	Номин Гал ХХК	"Pine nut kernels" хуш самарны чөмөг

14	Прайм Трейд Партнерс ХХК	Монголын чулуун давс
	Эс Си Интернэйшнл ХХК	"Pine nut oil" Хуш самарын чөмөгний тос
15	Сод Намнаа ХХК	Монголын чулуун давс
	Стимо ХХК	Гурилан бүтээгдэхүүн
16	Тэсо Корпораци ХХК	"Goldenmilk" хуурай сүү Лапша гоймон "100 жүүс" чацаргана "100 шүүс" нэрс
17	Силк Рөүд Трэйдинг ХХК	Бяслаг
18	Бий Фарм ХХК	Зөгийн бал
19	Үлэмж органик ХХК	Сүү, сүүн бүтээгдэхүүн
20	Норд роуд ХХК	"HushKhan" хуш модны самар
21	Пермакултур ХХК	Зөгийн бал
22	Михачи ХХК	Зөгийн бал
23	Очир алдар ХХК	Очир эрдэнийн амьд ус
24	Шимт Дээж ХХК	Чацарганы тос, чацарганы ундаа, дарс, оргилуун дарс үйлдвэрлэл
25	Алтай суль сульхар ХХК	Алтай монгол сүүтэй цай
26	Ентүм ХХК	Чацарганы дарс
27	Мөнх дэгжих гал ХХК	Мах, махан бүтээгдэхүүн
28	Жигүүр богд ххк	Ус ундаа, жүүс үйлдвэрлэл (чацарганы жүүс, тос)
29	Алтанбүрд оргил ХХК	Гурвалжин будаа

Хавсралт 2. Монгол Улсаас экспортолсон хүнсний бүтээгдэхүүний судалгаа
Хүснэгт Монгол улсаас 2012-2021 онд судалгаанд хамрагдсан улс орнууд руу
экспортолсон хүнсний бүтээгдэхүүн үнийн дүн, ам. доллараар

Он	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Судалгаанд хамрагдсан улсууд	30259	40811	46887	76165	93450	142755	192710	142985	125762	86726
Бүх улс	37460	48306	50504	79970	96974	158467	216255	172689	134905	179602


Бүдүүвч 1. 2012-2021 онд Монгол улсаас Дэлхийн нийт улс болон судалгаанд хамрагдсан улсад экспортолсон бүтээгдэхүүний харьцуулалт үнийн дүнгээр (ам.долл)



ТАЙЛБАР: 2012-2021 оны хугацаанд хүнсний бүтээгдэхүүний экспортын үнийн дүн 2.8-4.3 дээш дахин нэмэгдсэн байна.

Судалгаанд хамрагдсан улсуудын хүнсний экспорт, нийт хүнсний экспортын 88 орчим хувийг эзэлж байна.

Монгол улсаас Дэлхийн нийт улс болон судалгаанд хамрагдсан улсад экспортолсон хүнсний бүтээгдэхүүний харьцуулалт (хувиар).



Хүснэгт 2. Хүнсний бүтээгдэхүүний экспортыг экспортолсон нийт бүтээгдэхүүнтэй харьцуулсан байдал

	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Бүх бүтээгдэхүүн	4190058	3880897	5295114	4142297	4057351	5433692	6721469	6959552	5624674	13471621
Хүнсний бүтээгдэхүүн	30259	40811	46887	76165	93450	142755	192710	142985	125762	86726

Бүдүүвч 2. 2012-2021 онд Монгол улсаас нийт экспортолсон бүтээгдэхүүнтэй хүнсний бүтээгдэхүүнийг харьцуулсан байдал (ам.долл)


Бүх бүтээгдэхүүн болон Хүнсний бүтээгдэхүүн



ТАЙЛБАР: Судалгаанд хамрагдсан улсууд руу экспортолсон нийт бүтээгдэхүүнд хүнсний бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 2011 онд 0.95% байсан бол 2020 онд 2.2 % болж нэмэгдсэн байна.

Бүх бүтээгдэхүүн болон хүнсний бүтээгдэхүүний 2012-2021 онд экспортолсон нийт дүнгээр харьцуулсан байдал (хувиар)

Бүх бүтээгдэхүүн болон Хүнсний бүтээгдэхүүн



Монгол улсаас 2012-2021 онд экспортолсон хүнсний бүтээгдэхүүний жагсаалтыг БТКУС-ын 2 болон 4 оронтой код, үнийн дүн, мянган ам.доллараар. (Хавсралт 3, 4).

Хүснэгт 3. Хүнсний бүтээгдэхүүн экспортлосон улс орнууд, хэмжээ, ам. доллараар.

Судалгаанд хамрагдсан улсуудын 2012-2021 онд Монгол улсаас импортлосон хүнсний бүтээгдэхүүний хэмжээ, ам доллараар

Импортлогч	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Дэлхийн улс орнууд	37460	48306	50504	79970	96974	158467	216255	172689	134905	179602
Судалгаанд хамрагдсан улсууд	30259	40811	46887	76165	93450	142755	192710	142985	125762	86726
БНХАУ	8301	17667	31624	58819	77600	122878	170642	127997	112816	58718
Япон	87	69	805	1710	2551	1643	3047	3702	2797	4431
Итали	625	1417	1386	1919	2158	2296	2886	2798	2641	4277
Герман	6211	5757	2987	3555	1921	2049	2587	1362	389	2177
Катар	456	0	35	329	265	235	419	619	55	2016
БНСУ	264	249	268	550	1266	1211	1794	1669	994	1435
Нидерланд	355	89	166	2	0	41	0	21	1191	1279
Австри	3	1297	521	407	498	712	1132	1267	747	1101
Испани	2	1	15	73	46	22	21	5	1	833
Саудын араб	144	0	0	48	265	190	152	60	101	816
ОХУ	6734	5879	6877	6894	5971	8106	8645	1377	552	734
Египет	566	0	0	0	0	437	235	194	499	524
Ливан	0	337	93	15	0	0	471	377	921	307
Арабын нэгдсэн вант улс	5306	8049	2020	1717	772	2721	458	1067	1668	166
Польш	2	0	19	23	2	2	14	184	190	143
Бахрейн	0	0	0	0	0	104	125	0	0	1
Швед	0	0	1	0	2	1	1	3	2	0
Португал	0	0	0	0	0	0	0	0	1	0
Словак	0	0	0	0	0	0	0	0	1	0
Бельги	0	0	0	0	0	1	0	0	0	0
Чех	0	0	0	0	0	0	0	2	0	0
Дани	1	0	1	0	0	0	0	5	0	0

Унгар	1	0	0	0	0	0	1	7	0	0
Кувейт	1200	0	69	103	133	105	75	24	0	0
Люксембург	0	0	0	0	0	0	4	0	0	0

Хүснэгт 4. Хятад руу экспортолсон хүнсний бүтээгдэхүүний хэмжээ, ам. доллараар

Импортлогч	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Судалгаанд хамрагдсан улсууд	30259	40811	46887	76165	93450	142755	192710	142985	125762	86726
БНХАУ	8301	17667	31624	58819	77600	122878	170642	127997	112816	58718

Бүдүүвч 3. Монгол улсаас 2012-2021 онд экспортолсон хүнсний бүтээгдэхүүнийг судалгаанд хамрагдсан орнууд болон БНХАУ-тай харьцуулсан байдал үнийн дүнгээ (ам. долл).



ТАЙЛБАР: 2012 онд БНХАУ-ын Монгол улсаас импортлолсон хүнсний бүтээгдэхүүний хэмжээ 23% байсан бол 2021 онд 89.7% болсон байна.

2012-2021 онд Монгол улсаас экспортолсон хүнсний бүтээгдэхүүний нийт үнийн дүнгээр харьцуулав. (хувиар)



Хүснэгт 4. БНХАУ руу экспортолсон хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ, ам. доллараар

БТКУС	Бүтээгдэхүүний нэр	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Нийт	Хүнс, хүнсний бүтээгдэхүүн	10336	8301	17667	31624	58819	77600	122878	170642	127997	112816
16	Мах, загас, хавч төрөлтөн, нялцгай биетэн эсвэл усны сээр нуруугүй бусад амьтдаар хийсэн хүнсний бэлэн бүтээгдэхүүн.	5	5	14	7	8	1365	7864	78453	50061	60189
02	Мах, дайвар мах.	658	1115	7492	1239	3899	11180	38393	58816	57024	32787
12	Тослог үр, жимс; бусад үр, жимс; үйлдвэрлэлийн эсвэл эмнэлгийн зориулалттай ургамал; сүрэл болон тэжээл.	4485	3932	5066	20571	19444	17543	6236	9572	11659	10645
23	Хүнсний үйлдвэрээс гарсан үлдэгдэл болон хаягдал; мал, амьтны бэлдмэл тэжээл.	1089	896	2704	6707	3852	2476	3083	4657	3511	2865
21	Хүнсний төрөл бүрийн бэлдмэл	69	101	98	105	5398	708	1429	2025	1649	2773
05	Мал амьтны гаралтай, бусад газар заагдаагүй бүтээгдэхүүн.	2864	1110	1155	927	3022	1919	1717	3414	1293	1367
01	Амьд мал, амьтад.	53	36	33	38	2954	1539	110	179	283	908
15	Мал, амьтны эсвэл ургамлын гаралтай тос, тэдгээрийг задалж боловсруулсан бүтээгдэхүүн; идэшний өөх, тос; мал, амьтны эсвэл ургамлын гаралтай лав.	0	3	5	2	10	629	310	252	501	366
22	Согтууруулах болон согтууруулах бус ундаа, цуу.	5	14	22	51	126	1191	524	390	581	183
18	Какао болон какаоны бэлдмэл.	239	247	189	255	366	347	432	245	70	172

10	Үр тариа	0	0	0	0	258	0	0	18	483	142
08	Хүнсэнд хэрэглэдэг жимс болон самар; жүржийн төрлийн жимсний эсвэл гуаны хальс.	162	0	0	696	15826	33377	56884	11300	77	131
04	Сүү, цагаан идээ; шувууны өндөг; зөгийн цэвэр бал; мал амьтны гаралтай, бусад газар заагдаагүй хүнсний бүтээгдэхүүн.	41	20	21	10	27	115	1357	411	8	130
17	Саахар, саахран бүтээгдэхүүн.	250	350	550	615	1348	1258	1163	599	234	79
03	Загас, хавч төрөлтөн, нялцгай биетэн болон усны сээр нуруугүй бусад амьтад.	76	37	63	83	134	41	0	11	22	39
07	Хүнсний ногоо болон зарим үндэс үрт ба булцуут үрт хүнсний ногоо.	14	16	26	3	1	45	10	11	17	18
19	Үр тариан, гурилан, цардуулан эсвэл сүүн бэлдмэл; гурилан бүтээгдэхүүн.	170	401	181	173	437	497	200	151	437	17
20	Хүнсний ногоо, жимс, самар эсвэл ургамлын бусад эд хэсгээр хийсэн бэлдмэл	5	11	19	129	1080	134	138	69	74	5
06	Мод болон бусад ургамал; булцуу, үндэс ба эдгээртэй төстэй ургамлын бусад хэсэг; амьд цэцгийн баглаа болон чимэглэлийн ургамал.	146	4	23	0	611	3207	2975	7	0	0
09	Кофе, цай, парагвай цай болон амтлагч.	5	3	6	13	18	26	49	62	11	0


ТАЙЛБАР: Монгол Улсаас БТКУС-ын 2 оронтой ангиллын 24 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг экспортолж байгаагаас БНХАУ руу 20 төрлийн бүтээгдэхүүнийг экспортолж байна.

Хүснэгт 5. Япон руу экспортолсон хүнсний бүтээгдэхүүний хэмжээ, ам. доллараар

Импортлогч	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Судалгаанд хамрагдсан улсууд	30259	40811	46887	76165	93450	142755	192710	142985	125762	86726
Япон	87	69	805	1710	2551	1643	3047	3702	2797	4431

ТАЙЛБАР: Япон улс руу экспортолсон хүнсний бүтээгдэхүүний хэмжээ судалгаанд хамрагдсан улс орнуудын экспортод 2012 онд 0.2%-ийг эзэлж байсан бол 2021 онд 2.2% өссөн буюу үнийн дүнгээр авч үзвэл 30 дахин өссөн байна.

Судалгаанд хамрагдсан бусад орон болон Япон улсруу экспортолсон хүнсний бүтээгдэхүүний сүүлийн 10 жилийн нийт үнийн дүнгээр харьцуулбал (хувиар)



Хүснэгт 6. Япон руу экспортолсон хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ, ам. доллараар

БТКУС	Бүтээгдэхүүний нэр	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Нийт	Хүнс, хүнсний бүтээгдэхүүн	103	87	69	805	1710	2551	1643	3047	3702	2797
05	Мал амьтны гаралтай, бусад газар заагдаагүй бүтээгдэхүүн.	2	12	3	618	1203	1920	1428	1589	2838	2122
10	Үр тариа	0	0	0	86	365	347	0	933	169	71
23	Хүнсний үйлдвэрээс гарсан үлдэгдэл болон хаягдал; мал, амьтны бэлдмэл тэжээл.	25	0	0	0	2	101	22	225	545	447
02	Мах, дайвар мах.	67	42	35	48	51	64	73	65	16	0
20	Хүнсний ногоо, жимс, самар эсвэл ургамлын бусад эд хэсгээр хийсэн бэлдмэл	0	8	26	22	13	41	24	37	76	58
15	Мал, амьтны эсвэл ургамлын гаралтай тос,	0	15	1	9	59	51	26	39	21	82

	тэдгээрийг задалж боловсруулсан бүтээгдэхүүн; идэшний өөх, тос; мал, амьтны эсвэл ургамлын гаралтай лав.										
04	Сүү, цагаан идээ; шувууны өндөг; зөгийн цэвэр бал; мал амьтны гаралтай, бусад газар заагдаагүй хүнсний бүтээгдэхүүн.	0	0	2	1	2	18	9	59	11	11
18	Какао болон какаоны бэлдмэл.	0	0	0	0	0	0	18	77	0	0
08	Хүнсэнд хэрэглэдэг жимс болон самар; жүржийн төрлийн жимсний эсвэл гуаны хальс.	0	0	2	0	0	5	36	14	10	4
22	Согтууруулах болон согтууруулах бус ундаа, цуу	0	9	0	1	8	4	7	6	1	2
12	Тослог үр, жимс; бусад үр, жимс; үйлдвэрлэлийн эсвэл эмнэлгийн зориулалттай ургамал; сүрэл болон тэжээл.	9	1	0	18	0	0	0	0	0	0
11	Гурилын үйлдвэрийн бүтээгдэхүүн; амуу соёолж; цардуул; инулин; буудайн цавуулаг.	0	0	0	0	0	0	0	0	11	0
16	Мах, загас, хавч төрөлтөн, нялцгай биетэн эсвэл усны сээр нуруугүй бусад амьтдаар хийсэн хүнсний бэлэн бүтээгдэхүүн.	0	0	0	0	7	0	0	0	0	0
01	Амьд мал, амьтад.	0	0	0	2	0	0	0	0	0	0

ТАЙЛБАР: Монгол Улсаас БТКУС-ын 2 оронтой ангиллын 24 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг экспортолж байгаагаас Япон руу 14 төрлийн бүтээгдэхүүнийг экспортолж байна.

Хүснэгт 7. ОХУ руу экспортолсон хүнсний бүтээгдэхүүний хэмжээ, ам. доллараар


	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Судалгаанд хамрагдсан	30259	40811	46887	76165	93450	142755	192710	142985	125762	86726
ОХУ	6734	5879	6877	6894	5971	8106	8645	1377	552	734

Бүдүүвч 6. ОХУ-руу экспортолсон хүнсний бүтээгдэхүүний харьцуулалт



ТАЙЛБАР: ОХУ руу экспортолсон хүнсний бүтээгдэхүүний хэмжээ 2012 онд судалгаанд хамрагдсан улсуудад 22% байсан бол 2021 онд 1% хүрэхгүй хэмжээнд хүрсэн буюу үнийн дүнгээр авч үзвэл 90 дахин буурсан байна.

Сүүлийн 10 жилд экспортолсон хүнсний бүтээгдэхүүний нийтс үнийн дүнгээр харьцуулбал (хувиар).



Хүснэгт 8. ОХУ руу экспортолсон хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ, ам. доллараар

БТКУ	С	Бүтээгдэхүүний нэр	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
	Нийт	Хүнс, хүнсний бүтээгдэхүүн	22618	6734	5879	6877	6894	5971	8106	8645	1377	552
	02	Мах, дайвар мах.	21184	6008	1367	5792	6106	5238	6871	7133	739	28

16	Мах, загас, хавч төрөлтөн, нялцгай биетэн эсвэл усны сээр нуруугүй бусад амьтдаар хийсэн хүнсний бэлэн бүтээгдэхүүн.	242	133	0	143	458	225	762	1207	301	66
10	Үр тариа	323	248	2600	0	0	0	0	7	0	0
23	Хүнсний үйлдвэрээс гарсан үлдэгдэл болон хаягдал; мал, амьтны бэлдмэл тэжээл.	186	108	1242	0	0	0	0	0	10	84
22	Согтууруулах болон согтууруулах бус ундаа, цуу.	154	122	223	125	82	147	88	139	199	219
21	Хүнсний төрөл бүрийн бэлдмэл	499	84	4	43	72	172	80	102	102	142
07	Хүнсний ногоо болон зарим үндэс үрт ба булцуут үрт хүнсний ногоо.	0	0	390	572	112	0	148	0	0	0
12	Тослог үр, жимс; бусад үр, жимс; үйлдвэрлэлийн эсвэл эмнэлгийн зориулалттай ургамал; сүрэл болон тэжээл.	3	10	47	191	3	67	15	0	0	0
13	Лак; бохь, давирхай болон бусад ургамлын шүүс, ханд	0	8	0	0	3	88	102	0	0	0
05	Мал амьтны гаралтай, бусад газар заагдаагүй бүтээгдэхүүн.	1	6	0	3	12	9	4	10	7	8
01	Амьд мал, амьтад.	3	4	2	8	22	1	3	1	2	0
09	Кофе, цай, парагвай цай болон амтлагч.	0	0	4	0	0	10	10	14	2	2
08	Хүнсэнд хэрэглэдэг жимс болон самар; жүржийн төрлийн жимсний эсвэл гуаны хальс.	12	3	0	0	0	0	0	22	0	0
19	Үр тариан, гурилан, цардуулан эсвэл сүүн бэлдмэл; гурилан бүтээгдэхүүн.	0	0	0	0	0	6	4	8	15	3
20	Хүнсний ногоо, жимс, самар эсвэл ургамлын бусад эд хэсгээр хийсэн бэлдмэл	0	0	0	0	24	0	0	0	0	0
11	Гурилын үйлдвэрийн бүтээгдэхүүн; амуу соёолж; цардуул; инулин; буудайн цавуулаг.	0	0	0	0	0	0	19	2	0	0
15	Мал, амьтны эсвэл ургамлын гаралтай тос, тэдгээрийг задалж боловсруулсан бүтээгдэхүүн; идэшний өөх, тос; мал, амьтны эсвэл ургамлын гаралтай лав.	11	0	0	0	0	0	0	0	0	0
